



ХАНГАД ЭКСПЛОРЭЙШН ХХК

Сэнтрал Тауэр 16 давхар, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот, 14200 УБД: 9019015035
Утас: (976) 70122279
contact@mmc.mn, www.mmc.mn

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГА Х.ОТГОНМӨНХ ТАНАА

2025.10.31 № 243
танай _____ -ны № _____ -т

Тайлан хүргүүлэх тухай

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт байрлах Баруун наран төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хүргүүлж байна. Уг тайланг БОАЖС-н 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 4.1-р заалтын дагуу БОУАӨЯ-ны Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлангийн мэдээллийн санд 10-р сарын 31-ний өдөр илгээж, байршуулсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг илгээж, хүргүүлсэнтэй холбогдуулан ажлын хэсгийг томилон ажиллуулж, холбогдох дүгнэлтийг гарган өгч бидний ажилд дэмжлэг үзүүлж өгнө үү.

Хавсралт *65* хуудастай.

Хүндэтгэсэн,

ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

С.ЛХАГВА-ОЧИР





БАРУУН НАРАН ТӨСӨЛ

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН “БАРУУН НАРАН”
ОРДОД MV-014493 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР : MV-014493
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР : 2887134

Хянасан:

БОУАӨЯ-ны ХБОВХГ-ын
ахлах шинжээч _____

Ц. Жаргалнэмэх

Хэрэгжилтийг гаргасан:

“Хангад эксплорэйшн” ХХК-ийн
БОХАБЭА Нийцэл хариуцсан захирлын
үүрэг гүйцэтгэгч _____



Д. Батбаяр

“Хангад эксплорэйшн” ХХК-ийн
Байгаль орчны ахлах менежер _____

П. Батболд

2025 ОН

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
ТӨСЛИЙН ҮНДСЭН БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
БАРУУН НАРАН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН	7
4. СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	8
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	29
8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	30
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	31
11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	42
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	49
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	61
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА	65

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Баруун нарангийн чулуун нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций сумдын нутагт аймгийн төв Даланзадгад хотоос зүүн зүгт 61 км, нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт 550 орчим км зайнд оршдог ба 4485.64 га талбайд ашигт малтмал ашиглах MV-014493 тоот тусгай зөвшөөрлийн лицензийг Хангад Эксплорейшн компани эзэмшдэг. Хангад Эксплорейшн ХХК-ийн Баруун наран нүүрсний уурхай нь Монголын Уул Уурхайн Корпораци \Энержи Ресурс ХХК\ бүрэлдэхүүн хэсэг юм. Баруун наран уурхайг 2012 оны 1 сард улсын комисст хүлээлгэн өгч улмаар нүүрс олборлолтын ажлыг эхлүүлсэн. Баруун наран уурхайгаас Ухаа худаг уурхай хүртэлх нүүрс тээврийн хатуу хучилттай зам тавьж 2012 оны 11 сард улсын комисст хүлээлгэн өгсөн. Ингэснээр нүүрс тээвэрлэлтийн явцад үүсэх тоос шороо, хөрс, ургамал талхлагдах байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулснаас гадна тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангаж чадсан. Баруун наран уурхайгаас 2025 оны 10 сарын 30-ний байдлаар 2,780,780 тонн нүүрс олборлосон.



Хүснэгт 1.1. Тусгай зөвшөөрлийн талбайн газар зүйн координат

Уртгаг			Өргөрөг		
Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
105°	10'	0"	43°	37'	00"
105°	16'	0"	43°	35'	00"
105°	10'	0"	43°	38'	00"
105°	16'	0"	43°	34'	00"

Баруун наран уурхайн үйл ажиллагаа

Уурхайн нүүрсний үйлдвэрлэлийн нөөц 254.84 сая тонн болно. Энэхүү нөөцийг уурхайн ТЭЗҮ-д тусгагдсан хүчин чадлаар 26 жил ашиглахаар байна. Ордын уул-геологийн нөхцлөөс хамааруулан уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг экскаватор-автосамосвалын хослолоор гүйцэтгэнэ. Хөрсийг гадаад овоолгод, нүүрсийг уурхайн мөргөцөгөөс нүүрсний агуулах хүртэл, агуулахаас Ухаа худагийн баяжуулах үйлдвэр хүртлэх тус тус тээвэрлэнэ. Олборлосон нүүрсийг уурхайн түр агуулахаас Ухаа худаг хүртэл тээвэрлэхдээ 31.6 км зайд тусгайлан бэлдсэн хатуу хучилттай замыг ашигладаг.



Зураг 1.1. Уурхайн сэлбэгийн агуулах болон уурхайн оффис

Уурхайн тосгон нь ордоос хойд зүгт 6 км зайд байрладаг. Тосгонд ажилчдын байр, гал тогоо, хоолны заал, халуун усны газар, уурын зуух, материалын агуулах зэрэг барилга байгууламжууд байна.

Зам усалгаа ба ногоон байгууламжийн усалгаанд уурхайгаас гарах шүүрлийн ус, нэмэлтээр гүний худгийн ус ашиглана. Ундны болон ахуйн зориулалттай усыг уурхай ба тосгон дээр байрлах өрөмдмөл 2 гүний худгаас хангадаг болно. Цахилгаан эрчим хүчний хэрэглээг дизель генератор ашиглан хангаж байсан бол 2020 оны 9-р сард ЦДАШ-г ашиглалтанд оруулсан.

Уурхайн түлшний хэрэглээг уурхайн талбайд байрлах 50м³ х 4 нөөцлүүр бүхий шатахуун түгээх станцаас хангана. Хотхоныг Барууннаран ил уурхайгаас хойд зүгт 6км зайд байгуулсан. Уурхайн хотхонд захиргааны байр, халуун усны газар, ажилчдын байр, ИТА-ын байр, материалын агуулах зэрэг барилга байгууламжуудаас бүрдэнэ. 2024 онд Баруун наран уурхайн гэрээт компаниуд нь цутгамал төмөр бетон суурьтай, метал рамтай, чулуун хөвөн дулаалгатай сэндвичэн хавтан өнгөлгөөтэй ажилчдын амрах байрыг шинээр ашиглалтанд оруулсан.



Зураг 1.2. Уурхайн ажилчдын хотхон

Нүүрс тээвэрлэлтийн авто зам: Баруун нарангаас Ухаа худаг уурхай руу нүүрс тээвэрлэх зорилгоор 31.8 км урттай хатуу хучилттай авто замыг 2012 оны 11 сард ашиглалтанд оруулсан. Нүүрсийг Ухаа худаг дахь баяжуулах үйлдвэрт боловсруулан, Ухаа худаг-Гашуун сухайт чиглэлд тээвэрлэж, экспортолно.

Баруун наран – Ухаа худаг чиглэлийн нүүрс тээвэрт хатуу хучилттай замыг ашиглаж байгаа нь уурхайн тээвэрлэлтийн хүчин чадал нэмэгдэж, зардал буурах боломжтой болж байгаагаас гадна хайрган зам ашигласнаас үүсэх тоосжилтыг бууруулж, говь нутгийн байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахад ихээхэн ач холбогдолтой юм.

Хатуу хучилттай зам нь цаг агаарын бүх нөхцлийг даах чулуун бүтэцтэй ба 100 тоннын даацтай тээврийн хэрэгсэл явахад зориулагдсан байна. Баруун наран- Ухаа худаг чиглэлийн хатуу хучилттай зам нь 10.5 метр өргөн, хөдөлгөөний 2 зурвастай, замд ус тогтохгүйгээр шууд зайлуулах бүрэн боломжтой.

1.2 Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын “Баруун нарангийн” нүүрсний орд нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Халхын дундад ба Дарьгангын талархаг мужийн А тойрог ухаа гүвээт халхын дундад талд хамрагдана.

Байгалийн мужлалаар Говийн их мужийн бор хөрсний бүсэд багтах ба газрын гадарга, газарзүйн хувьд нам уулс, ухаа гүвээ толгодод хамрагдана. Эдгээр нам уулс, ухаа гүвээ хооронд өргөн уудам задгай уудам хөндий, урт шилүүд үүсчээ.

Нам уулс, ухаа гүвээ толгод нь далайн түвшнээс дээш дунджаар 1500-1600 м орчим өндөрт, харин өргөн уудам задгай хөндий далайн түвшнээс дээш 1550 м өндөрт тус тус тогтоно. Энд хамгийн өндөр цэг Бумбатын хяр уул далайн түвшнээс дээш 1600 м, хамгийн нам цэг уурхайгаас урагш дэрстэй хоолой 1180 м өндөрт өргөгджээ.

1.2.1. Баруун наран уурхай орчмын хөрсний хэв шинжийн онцлог

Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь байгалийн мужлалаар Говийн их мужийн бор хөрсний бүсэд багтах ба газрын гадарга, газарзүйн хувьд нам уулс ухаа гүвээ толгодод хамрагдана. Хөрсний хээрийн судалгаа ба лабораторийн шинжилгээний үр дүнд үндэслэж доор дурьдсан хөрсний хэв шинж, дэд хэв шинж, төрөл, зүйлийг тогтоосон. Үүнд:

- Нам уулс, ухаа гүвээ толгодын сул хөгжилтэй чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн тал хөндийн үүрмэг чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн тал хөндийн чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн нугархаг хөрс
- Гуу жалга сайрын хөрс

1.2.2. Уур амьсгалын тойм

Даланзадгад хотын сүүлийн 10 жилийн агаарын температурын мэдээнээс харахад жилийн агаарын дундаж температур нь 5.8°C байна. Цогтцэций сумын жилийн агаарын дундаж температур 4.3°C байдаг байна. Жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар буюу дундаж агаарын температур нь $12.9 - -13.7^{\circ}\text{C}$, хамгийн дулаан сар нь 7 дугаар сар буюу дундаж агаарын температур нь $+23.1 - +24.5^{\circ}\text{C}$ байдаг байна. Уур амьсгалын дулаарлаас болж жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа, хүйтний нөөц багасч, дулаан үеийн үргэлжлэх хугацаа уртасч дулааны нөөц нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Төсөл хэрэгжих Баруун Нарангийн уурхай нь харьцангуй нам дор, өргөн уудам хөндийд, алсуураа говийн уулс, нам толгод, гүвээгээр хүрээлэгдэн орших ба жилийн ихэнх хугацаанд буюу дунджаар 210 орчим хоног дулаан байдаг байна.

Энэ бүс нутагт жилдээ 104.3 мм орчим хур тунадас унадаг. Хур тунадасны хэмжээ жилийн дотор нилээд өөрчлөлттэй хуваарилагддаг буюу 4-10 дугаар саруудад жилийн нийт хур тунадасны 6893% нь унадаг боловч зөвхөн 7-8 дугаар саруудад 60-70% орчим нь унадаг байна. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын дулаарлаас шалтгаалан зүсрэн орох бороо цөөрч гол төлөв хүчтэй аадар борооны тоо олшрох болсон.

Жилийн дундаж салхины хурд 2.4-5.1 м/сек ба сүүлийн 10 жилд салхины хурд хамгийн ихдээ 30 м/сек хүрч ширүүсч байсан байна. Төслийн бүс нутагт хаврын улиралд салхины хурд харьцангуй их буюу 4.3-5.1 м/сек хурдтай байдаг. Өвлийн улиралд баруун, баруун хойд, хойд чиглэлийн салхи зонхилж байснаа зуны улиралд өмнөд зүгийн салхины давтагдал нэмэгдэж ирдэг зүй тогтолтой. Агаарын харьцангуй чийгшлийн их утга нь өвлийн саруудад ажиглагдах бөгөөд 1 ба 12 дугаар саруудад 50-68% байна. Хавар намарт агаарын харьцангуй чийгшлийн бага утга буюу 22-47% ажиглагдана.

1.2.3. Ургамлан нөмрөг, түүний онцлог

Оорцогийн хоолой буюу төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 20 овог, 46 төрөлд хамаарах 70 зүйл ургамал бүртгэгдсэн. Зүйлийн тоог нийт 4485,64 га талбайн хүрээнд харьцуулбал ургамлын янз зүйл 0.01 буюу төдийлэн баялаг биш ч тухайн говь цөлийн нөхцөлд байх ёстой хэмжээндээ байгаа юм. Овгуудын дотор хамгийн олон зүйлтэй нь Луулийн овог 11 зүйлтэй, Нийлмэл цэцэгтний овог 10 зүйлтэй, Үетний ба Буурцагт ургамлын овог тус бүр 5 зүйлтэй, бусад нь 1-2 зүйлтэй. Зүйлийн бүрдэлд унаган ургамлын тоо 9, Монгол улсын Улаан номонд орсон ховор зүйл 3 байна. Түүнчлэн зүйлүүдийн дотор 10 зүйл сөөг, 14 зүйл заримдаг сөөг, 1 зүйл сөөгөнцөр, 7 зүйл нэг наст ургамал байгаа бөгөөд бусад 28 зүйл ургамал нь олон наст өвслөг ургамал юм.

1.2.4. Амьтны аймаг, түүний онцлог

Төслийн талбай нь цөлөрхөг хээрийн бүслүүрт хамрагдаж байгаа бөгөөд Монгол орны хөхтөн амьтдын газар зүйн мужлалаар Дорнод говийн мужид хамрагдаж байгаа юм. Бүс нутгийн ургамлан нөмрөгийг шүтэн өөхөн сүүлт атигдаахай, таван хуруут атигдаахай, соотон алагдаага, элсч савагдаахай, зэгэл алаг дааганцар, монгол даахай, бүрдийн шишүүхэй, орог зусаг, хадны барагчин, түвд ов, шар чичүүл, дагуур огдой зэрэг мэргэгчид байх ба түүгээр хооллодог маануул мий, саарал чоно, хярс үнэг, шар үнэг, өмхий хүрэн зэрэг амьтад байхаас гадна хулан адуу, янгир ямаа, хар сүүлт, аргаль хонь, цагаан зээр зэрэг салаа битүү туурайтан амьтад идээшилж бэлчээрлэдэг.

Баруун нарангийн талбайн хэмжээнд 6 багийн 35 зүйл хөхтөн амьтад тэмдэглэгдсэн байна. Эдгээрээс шилүүс, цоохондой, чоно, үнэг, хулан, янгир, хар сүүлт зээр, цагаан зээр зэрэг том хөхтөн амьтад нь ихэвчлэн хайгуулын талбайн баруун урд талаар орших уулс тэдгээрийн хооронд хөндийгөөр тохиолдоно. Харин талбай дотор ихэвчлэн жижиг мэргэгчид тархсан байдаг.

Суурь судалгааны хугацаанд 32 зүйл шувуу хайгуулын талбай болон орчмын бүсэд тэмдэглэгдсэн байна.

ТӨСЛИЙН ҮНДСЭН БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Баруун наран уурхайгаас нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг төслийг хэрэгжүүлэх байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тодорхойлсон байдаг.

Нүүрс олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

2.1. Агаарын чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөллүүд:

- Ил уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлох, ачиж буулгах үйл ажиллагаа болон хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт тоосонцорын хэмжээ ихсэх
- Элэгдэл эвдрэлд өртсөн газраас салхины нөлөөгөөр тоосжилт үүсэх
- Тэсэлгээ, уурхайд ажиллаж байгаа техник, тоног төхөөрөмжөөс үүсэх дуу шуугиан, Галлагаа, хүнд даацын болон бусад техникээс бохирдуулагч хий үүсэх

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Нүүрс ачиж буулгах талбай дахь нүүрсний овоолгуудыг удаан хугацаагаар хадгалснаас нүүрс өөрөө халж шатсанаас хүлэмжийн хий ялгарах
- Төслийн хэмжээнд ашиглаж байгаа хатуу хучилттай зам эвдрэх, зам засах зэргээс шалтгаалан шороон зам гарган ашигласнаас агаарт тоосжилт үүсэх

- Шатахуун түгээх станц, тос тосолгооны материалын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас агаарт бодис материал ууршин тухайн орчны агаарыг бохирдуулах.

2.2. Усны чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Уурхайн олборлолтын явцад шүүрүүлэлтийн усыг шавхсанаас гүний усны түвшин буурах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Уурхайн хотхон болон ажилчдын кэмпийн бохир ус цэвэрлэх байгууламжийн эвдрэл гэмтэл, технологийн горим алдагдсанаас үүдэн гадаргын болон газрын доорх усны чанар найрлагад нөлөөлөх.
- Хаягдал чулуулгийн овоолго дахь хүчил шүлтийн тэнцвэр алдагдаж хүчиллэг урсацын нөлөөгөөр гадаргын болон газрын доорх ус бохирдох.

2.3. Хөрсний чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын хэлбэр төрхөд өөрчлөлт орох.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орох.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарснаас шалтгаалан хөрс бохирдох.
- Хатуу хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.
- Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.

2.4. Ургамлан бүрхэвчид үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын ургамлан бүрхэвч устгах.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан ургамлын ургалтанд нөлөөлөх.
- Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт ургамлын гадаргууд бууснаар фотосинтезийн процессийг багасгаж ургамлын ургалтанд нөлөөлөх

2.5. Биологийн төрөл зүйлд үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Уул уурхай түүнийг дагасан үйлдвэр, суурьшлаас тухайн бүс нутгийн амьтан дайжих, дүрвэх.
- Уурхайн хөрс хуулалт, хашаажуулалт зэргээс амьтны амьдрах орчин, идэш тэжээл хязгаарлагдах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Нүүрс тээврийн зам хөндлөн гарах амьтад машинд дайруулах.

БАРУУН НАРАН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН

Өмнөговь аймгийн Ханхонгор суманд орших Баруун нарангийн ордоос нүүрс олборлох, тээвэрлэх төслийн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийн байдлыг нэг бүрчлэн тодорхойлж, шаардагдсан хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

2025 оны Баруун наран уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал.

- Ханхонгор сумын Мандах багийн нутаг орших Гэр овоо нэртэй газар гар аргаар алт олборлосон 2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг ажлыг гүйцэтгэж, орон нутгийн ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.
- Ханхонгор сум Мандах багийн нутагт байрлах “Ар бумбат” булгийн эхийг хашаалах ажлыг 2025.09.15-17-ны өдөр хийж гүйцэтгэсэн. Хашааны нийт урт 185метр ба 58 шонтой үүнээс 80метр төмөр арамтай үлдсэн 105м сунадаг торон хашааг гагнаж хашаалав. Хашаалах ажлыг хийж гүйцэтгэсний дараа тухайн булагтай ойр зусаж буй булгийн эхийг хашаалах хүсэлт гаргасан нутгийн иргэнд /Б.Данзанхүү, Номиндэлгэр/ хүлээлгэн өгсөн.
- Баруун наран уурхайн нөлөөллийн бүсийн малчид, орон нутгийн бусад малчин өрхүүддээ өвөл хаврыг өнтэй давахад нь туслах зорилгоор жил бүр өвс, тэжээлийн тусламжийн дэмжлэг үзүүлсэн.
- Уурхайн шимт хөрсний хуулалт хийгдэх талбайд мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэж хуулах талбайн шимт хөрсний үе давхарыг зураглал хийлгэж, шимт хөрсний нөөцийг бүрэн авч хадгалж байна.
- Ажилчдын тав тухыг хангах, үзэгдэх орчныг сайжруулах зорилгоор ажилчдын хотхонд энэ жил 2600 м² талбайг зүлэгжүүлэх ажлыг төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу зүлэгжүүлэлтийн ажил хийгдсэн.
- Баруун наран уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй ба гол сөрөг нөлөөллийг хянах зорилгоор агаарын чанар, газар доорх ус, хөрсөн бүрхэвч зэрэг чиглэлээр орчны хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
- Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт байрлах Загт товог гэх газар байгалийн заган ойг түшиглэн Байгаль хамгаалагч Ц. Батбэхийн санал болгосон 5га талбайг хашаалан салхин дээд талд нь хамгаалалтын зурвас үүсгэн 1000 жигд мод тарьсан. Хойшид байгалийн заган ойг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

Хүснэгт 2. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт

д/д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	12	12	-
2	Нөхөн сэргээлт	3	3	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	3	3	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	1	1	-
5	Осол эрсдлийн менежмент	5	5	-
6	Хог хаягдлын менежмент	6	6	-
7	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	6	6	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	9	9	-
9	Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа	5	4	1
Нийт		50	49	1

4. СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулах чиглэлээр

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Усны машин ашиглан тоосжилт үүсэх зам, талбайг услах	Ил уурхай	Уурхайгаас шүүрэх шүүрлийн ус болон худгийн уснаас 20 тоннын 3, 18 тоннын 1 зориулалтын шүршдэг усны машинаар зам талбайг услаж байна. Зам усалгаанд нийт 97,440м3 усаар зам усалсан байна.	Үйлдвэрлэлийн зардлаас	500 м ³ /сар
2	Уурхайн технологийн машины хурдны хязгаарт хяналт тавьж, замын арчилгааг хийж үүсэх тоосыг бага байлгах	Ил уурхайн	Уурхайн тенологийн замын арчилгааг грэйдер, утгуурт ачигчаар зам арчилгааг хийж байна. Мөн замын дагуу хурд хэмжигч байрлуулж өдөр бүр тогтмол хяналт тавьж байна.		50км\ц
НИЙТ ЗАРДАЛ, мян төг				-	

1.1. Усны машин ашиглан тоосжилт үүсэх зам, талбайг услах

Тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайгаас шүүрэх шүүрлийн ус болон худгийн уснаас 20 тоннын 3, 18 тоннын 1 зориулалтын шүршдэг усны машинаар зам талбайг услаж байна. Уурхайд ажлын байрны үзлэгийг тогтмол хийж технологийн замд эвдрэл гэмтэл гарах тухай бүрд туслах техник ашиглаж засвар үйлчилгээг хийж тоосжилтын хэмжээг бууруулж байна. Ингэснээр уурхайн зүүн карьерт 20 болон 18 тонны 4 усны машин ажиллаж зам усалгааг тасралтгүй хийж байна. Зам усалгаанд нийт **97,440м³** усаар зам усалсан байна.




Зураг 4.1.1.1. Уурхайн технологийн замын усалгаа

4.1.2. Уурхайн технологийн машины хурдны хязгаарт хяналт тавьж, замын арчилгааг хийж үүсэх тоосыг бага байлгах

Баруун наран уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгслийн хурдыг дотоод журмын дагуу технологийн замд 50км\ц, налуу замд 30км\ц, отвол дээр 40км\ц, нүүрсний овоолго дээр 10км\ц, засварын талбайд 10 км\ц байхаар зааж хурд хэмжилтийг хийж, цаг агаарын саатал, хэт их тоосжилттой үед хурдыг нэг дахин багасгах, уулын ажлыг түр болон хэсэгчлэн зогсоох арга хэмжээ авч ажиллаж байна. Хурдыг хязгаарлах зорилгоор хурд хянагч автомат самбар, зайнаас хурд тандах зориулалт бүхий gps-р тогтмол хянаж байна. Технологийн замуудад материал дэвсэлт хийх, түйрэн хаялагыг цэвэрлэх зам арчилгааг тогтмол хийж байна.



Зураг 4.1.2.1 Хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ



Зураг 4.1.2.2 Уурхайн замын тэмдэглэгээ ба GPS-ийн хяналт



Зураг 4.1.2.3 Уурхайн замын тоос, тоосонцор дэгдэхээс сэргийлж Технологийн замуудад материал дэвсэлт хийсэн.

4.2. Газар доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

№	Байгаль орчны хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Уст цэгт хамгаалах, сайжруулж сэргээх ажил зохион байгуулах	Уурхай орчмын уст цэгүүд	Ханхонгор сум Мандах багийн нутагт байрлах "Ар бумбат" булгийн эхийг хашаалах ажлыг 2025.09.15-17-ны өдөр хийж гүйцэтгэсэн.	5,700.0	1
2	Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох байгууллагаар гаргуулж гэрээ байгуулах,	Хангад эксплорэйшн ХХК	Усны газраас 2025 оны 2-р сарын 27-ны өдөр ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаатай 2025 оны 4-р сарын 08-нд ус ашиглах гэрээ байгуулан ажиллаж байна.	Үйл ажиллагааны зардлас	1-р улиралд
3	Цэвэрлэх байгууламжийг ашиглалтанд оруулж, горимын дагуу ажиллуулж саарал усыг дахин ашиглах;	Ажилчдын хотхон	2025 онд "ХАНГАД ЭКСПЛОРЭЙШН" ХХК-ний Ажилчдын шинэ байр ашиглалтад орж цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа горимын дагуу явж байна. Цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг дахин ашиглах стандартын шаардлагад нийцүүлэх зорилгоор кэмийн угаалгын хэсэгт угаалгын нунтаг, бодисыг шүүх зориулалтаар 3 давхар шүүлтүүр нэмж байршуулсан. Цэвэрлэх байгууламжийн 5 танкны дулаалга хийж, 15х4 харьцаатай сендвичэн барилга шинээр барьсан	Үйл ажиллагааны зардлас	1-12 сар
4	Богвойн шанд малчдын гар худаг болон уст цэгийг цэвэрлэх	Уурхай орчмын уст цэгүүд	SGC mining ХХК, UARP ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн Б.Баасандорж, Ү.Булгантамир нар Богвойн шанд малчны худаг уст цэгийн цэвэрлэгээг зохион байгуулж 06 сарын 12-ны өдөр хийж гүйцэтгэсэн.	600.0	1
НИЙТ ЗАРДАЛ, мян төг				6,300.0	

4.2.3. Цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, горимын дагуу ажиллуулж саарал усыг дахин ашиглах

Баруун наран уурхайн ажилчдын 2 кемпийн цэвэрлэх байгууламж нь 4 хэсгээс бүрдсэн, 16 м³-ын багтаамжтай 1 танк, 7 м³-ын багтаамжтай 1 септик танк, 3.2 тонны багтаамжтай 1 септик танк, 5 м³-ын багтаамжтай танкнуудыг тус тус цуваа холболтоор суурилуулан ажилуулж байна. Өдөрт 10 м³ усыг 98 % хүртэл цэвэршүүлэн саарал усыг ариун цэврийн суултуурт эргэлтийн усны насосоор дахин шахаж ашиглахаар төлөвлөн ажиллаж байсан боловч цэвэрлэх байгууламжаас гарах цэвэрлэгдсэн бохир усны шинжилгээ нь байгальд нийлүүлэх цэвэрлэгдсэн бохир усны стандартын шаардлага хангахгүй байсан тул одоогоор Цогтцэций суманд байрлах “Энержи Ресурс ХХК”-ийн бохир ус цэвэрлэх байгууламжид нийлүүлж байна.



Зураг 2.2.3.1. Бохир ус цэвэрлэх байгууламж болон саарал ус шингээх талбай

Нян үржүүлэх мөн саарал усаа бохир усны стандартын шаардлагад нийцүүлэх зорилгоор кемпийн угаалгын хэсэгт угаалгын нунтаг, бодисыг шүүх зориулалтаар 3 давхар шүүлтүүр нэмж байршуулсан.



Зураг 4.2. Угаалгын хэсэгт 3 давхар шүүлтүүр байршуулсан



Зураг 4.2. Цэвэрлэх байгууламжийн 5 танкны дулаалга 15х4 харьцаатай сендвичэн барилга барьсан

4.2.4. Уст цэг цэвэрлэх

Баруун наран уурхайн нөлөөллийн бүсэд байдаг Богвойн шанд малчдын гар худгийн цэвэрлэгээг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр 4 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж нийт 0.5м3 гаруй ахуйн хог хаягдлыг цэвэрлэж, уст цэгийн үзэгдэх орчныг сайжруулсан.



Зураг 4.2.1. малчдын худаг, уст цэгт цэвэрлэгээ хийсэн

4.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих	Ил уурхай	2025 онд шимт хөрсний 2 овоолго шинээр үүсгэж стандартын дагуу хадгалж байна. Хуулах хөрсний давхаргын зургийн дагуу шимт хөрсийг зохих журмын дагуу хуулалт хийгдэж, хяналтыг тогтмол тавьж байна.	Үйлдвэрлэлийн зардлаас	Шимт хөрсний хуулалт ба хадгалалт стандарт хангасан байх

2	Нүүрс тээврийн автомашинуудад хучлага ашиглах	Нүүрс тээврийн үйл ажиллагаа	Баруун наран уурхайгаас Ухаа худаг чиглэлд нүүрс тээвэрлэж буй тээврийн машинуудад зориулсан хучлага бүтээх хэсэгт тээврийн машинуудыг хучлагыг тогтмол хучиж нүүрсний асгаралтаас сэргийлэн ажиллаж байна.	Үйлдвэрлэлийн зардлаас	Бүх автомашиныг хучлагатай явуулах
	НИЙТ ЗАРДАЛ, мян төг			-	


4.3.1. Уржил шимт хөрснийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих

Уурхайн ухмал болон хаягдал чулуулгийн овоолгын тэлэх талбай болон бусад үйл ажиллагааны нөлөөгөөр эвдрэлд орох газрын шимт хөрсийг “Газар шорооны ажлын үед уржил шимт хөрс, хуулалт, хадгалалт MNS 5916:2008” стандартын дагуу хуулж хадгалдаг. Шимт хөрсний овоолго тус бүрийг дугаарлаж овоолго хийсэн огноо, хөрсний эзлэхүүн зэрэг мэдээллүүдийг оруулан бүртгэлжүүлж байна. Тайлант хугацаанд хаягдал чулуулгийн талбайн тэлэлтэй холбогдуулан м³ шимт хөрсийг хуулан овоолго үүсгэсэн байна.

ШИМТ ХӨРСНИЙ БҮРТГЭЛ

Барууннаран 2025 он

№	Огноо	Хуулалт хийсэн талбайн байршил	Талбайн хэмжээ м²	Шимт хөрсний хэмжээ м³	Хөрс хуулалтын гүн см	Бүртгэл хөтөлбөр мөргөмжлөн
1	2024.12.20	Карьерийн хойд талалт	67311.68	20506.4	30	Д.Энхтайван
2	2024.12.28	Карьерийн хойд талалт	22354	6708	30	Д.Энхтайван
3	2024.12.30	Шимт хөрсний шинэ овоолго явах зам	7534.4	2260	30	Д.Энхтайван
4	2024.12.30	Эцэн захын ТС овоолгын талалт	6928	2078	30	Д.Энхтайван
5	2025.01.14	Карьерийн талалт	19473.8	7789.5	40	Л.Мөнхсүх
6	2025.01.26	Шинэ овоолгын 13-р овоолго талалт	18870.2	5681.6	20	Д.Энхтайван
7	2025.02.16	Хаягдлын овоолго 181-ын талалт	42969.6	12,890	10	Д.Энхтайван
8	2025.02.21	Хаягдлын овоолго 181-ын талалт	81,914	32,795	40	Д.Энхтайван
9	2025.03.19	Шинэ зочны талбайн зам	19758	59274	30	Д.Энхтайван
10	2025.04.02	Карьерийн талалт	60918	1827	30-40	Л.Мөнхсүх
11	2025.04.16	Баруун талын шинэ зам	51820.2	15542	30-40	Д.Энхтайван
12	2025.05.07	Шинэ 3-р овоолго талалт	59375	17812	30-40	Баасандорж
13	2025.06.14	Баруун талын шинэ замын	52248.8	15674.6	30-40	Баасандорж
14	2025.07.02	Карьерийн баруун талалт	78423.3	23828.9	30-50	Д.Энхтайван
15	2025.08.27	Паркийн талбайн талалт	3301	660	30	Д.Энхтайван
16	2025.09.24	Нүүрс газарын шинэ зам 2-ын зам хооронд	314	94.2	30	Баасандорж
Нийт			594,312.18	225,337.2		





Зураг 4.3.1.1. Шимт хөрс хуулж байгаа нь

4.3.2. Нүүрс тээврийн автомашинуудад хучлага ашиглах

Баруун наран уурхайгаас Ухаа худаг чиглэлд нүүрс тээвэрлэж буй тээврийн машинуудад зориулсан хучлага бүтээх хэсэгт тээврийн машинуудыг хучлагыг тогтмол хучиж нүүрсний асгаралтаас сэргийлэн ажиллаж байна.



Зураг 4.3.2.1. Нүүрс тээвэрийн машиныг хучиж байгаа нь

4.4. Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Оффис орчмын ногоон байгууламжийн модны усалгаа, арчилгааг зохион байгуулах	Уурхайн талбай	Оффис болон ногоон байгууламжинд таригдсан 1497 ширхэг модны усалгааг 5-р сараас эхлүүлж, хог ургамал түүх болон идэвхтэй өсөлт хөгжилт ургалтын хугацаанд нэмэлтээр гумины шингэн бордоо хийж өгсөн.	2,000.0	Жилд 5-10 сарын хооронд
2	Кемпийн явган замын дагуу талбайг зүлэгжүүлэх	Ажилчдын хотхон	Ажилчдын хотхонд энэ жил 2600 м ² талбайг зүлэгжүүлэх ажлыг төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу зүлэгжүүлэлтийн ажил хийгдсэн.	4,000.0	20м2
3	Амьтан ажиглалтын камер байршуулах	Лицензийн талбай уст цэг	Баруун наран уурхайн баруун хэсэгт зэрлэг ан, амьтдад зориулсан уст цэг болон хяналтын камер байршуулан тогтмол хяналт тавьж ажиллаж байна.	1,600.0	Сар тутам
4	Ухаа худагаас Баруун наран явах цахилгаан шугамын дагуу шувуудын хорогдол гарч буй эсэхэд ажиглалт явуулах,	ЦДАШ	Баруун наран уурхайгаас Ухаа худгийн 88-р пост хүртэл цахилгаан дамжуулах агаарын шугамын дагуу 2025 оны 05-р сарын 12, 09-р сарын 12-ний өдрүүдэд шувуудын хорогдлын ажиглалт хийж гүйцэтгэв.	1,000.0	Жилд 1-2 удаа
НИЙТ ЗАРДАЛ, мян төг				14,900.0	

4.4.1. Оффис орчмын ногоон байгууламжийн модны усалгаа, арчилгааг зохион байгуулах

Ногоон байгууламж нь тухайн газрын агаарыг цэвэршүүлж, агаарыг чийгшүүлж, шороо тоосжилтыг багасгаж байдгаас гадна хүмүүсийн ажиллаж амьдрах тохитой нөхцөлийг бүрдүүлж, тухайн газрын экосистемийг зохицуулдагаараа өндөр ач холбогдолтой. Ийм учраас оффис болон ногоон байгууламжинд таригдсан 1497 ширхэг модны усалгааг 5-р сараас эхлүүлж, хог ургамал түүх болон идэвхтэй өсөлт хөгжилт ургалтын хугацаанд нэмэлтээр гумины шингэн бордоо хийж өгсөн. Мөн уурхайн оффисын гадна явган зам дагуу 400м2 талбайн зүлэгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэсэн.



Зураг 4.4.1.1. Баруун наран уурхайн оффис орчимд хуваарьт усалгаа хийж байгаа нь



Зураг 4.4.1.2 Уурхайн оффисын зам дагуу зүлэгжүүлэлтийн ажил хийсэн.

4.4.2.Кемпийн явган зам дагуу зүлэгжүүлэлт хийх

Ажилчдын тав тухыг хангах, үзэгдэх орчныг сайжруулах зорилгоор ажилчдын хотхонд энэ жил 2600 м² талбайг зүлэгжүүлэх ажлыг төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу зүлэгжүүлэлтийн ажил хийгдсэн.



Зураг 4.4.2.1 Кэмпийн зүлэгжүүлэлт хийгдсэн байдал

4.4.3. Амьтан ажиглалтын камер байршуулах

Их-Уулын уст цэгт зэрлэг ан амьтдад зориулсан уст цэгт болон уурхайн баруун тийш 5км-т хуванцар хоолой байрлуулан газарт булж жижиг ан амьтан ус уух боломжтой уст цэгийг байгуулав. Усны онгоцны хажууд камер шинээр байрлуулж, төмөр суурь, таних тэмдэг бүхий пайзтай болгов.



Зураг 4.4.3.1.. Амьтан ажиглах зорилгоор шинээр байрлуулсан камер болон уст цэг



Зураг 4.4.3.2. Их Уулын уст цэгийн ажиглалтын камерт ажиглагдсан амьтад

4.4.4. Ухаа худагаас Баруун наран явах цахилгаан шугамын дагуу шувуудын хорогдол гарч буй эсэхэд ажиглалт явуулах

Баруун наран уурхайгаас Ухаа худгийн 88-р пост хүртэл цахилгаан дамжуулах агаарын шугамын дагуу 2025 оны 05-р сарын 12, 09-р сарын 12-ний өдрүүдэд шувуудын хорогдлын ажиглалт хийж гүйцэтгэв. Уг хоёр удаагийн ажиглалтаар тогонд цохиулан үхсэн шувуу ажиглагдсангүй. Харин тавдугаар сард хийсэн ажиглалтаар төмөр тулгуур бүхий шонгуудад хэрээ шувуу үүрлэсэн байв. Есдүгээр сарын ажиглалтаар 6-р сараас хойш тоггүй байсан 118, 173 дүгээр гэрлийн шонгийн хажууд байрлах өндөр хүчдэлийн төмөр шон дээр шувууны үүр байсан бөгөөд 2 шувуу байсан.



Зураг 4.4.4.1. Баруун нарангаас Ухаа худаг хүрэх
төмөр тулгуур бүхий шонд үүрлэсэн шувууны үүр



Зураг 4.4.4.2. Баруун нарангаас Ухаа худаг хүрэх 118, 173 дүгээр шон дээр зассан үүр

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Ажилчдын хотхон орчмын мод тарьсан талбайн модны усалгаа, арчилгааг зохион байгуулах	Ажилчдын хотхон орчим мод тарьсан талбай	Ажилчдын хотхон урд байрлах 2 га талбайн 5000 модны усалгааг арчилгааг 5-р сараас эхлүүлж, хог ургамал түүх болон идэвхтэй өсөлт хөгжилт ургалтын хугацаанд нэмэлтээр гумины шингэн бордоо хийж өгсөн. Хаврын тарилтаар 1000 мод, намарын тарилтаар 100 мод тарьж модны амьдралтын хувь 8ай ургаж байна	3,000.0	2 га
2	Уурхайн орчмын ногоон байгууламжийн модны нөхөн тарилтыг хийх	Зам дагуух ногоон байгууламж	Баруун наран уурхай 2025 оны байдлаар нийт 1000мод тарьсан ба ургалтын байдал 90% -тай байна	5,000.0	1000ш
3	Говийн ховор, нэн ховор ургамал хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээ		Баруун наран уурхайн ажилчдын хотхонд 1000ш буйлс модыг үрээр тарьж үржүүлэх ажлыг хийсэн.	3,000.0	1000ш
	НИЙТ ЗАРДАЛ, мян төг			11,000.0	

5.1. Ажилчдын хотхоны мод тарьсан талбайн усалгаа, арчилгааг зохион байгуулах

Ажилчдын хотхон урд байрлах 2 га талбайн 5000 модны усалгааг арчилгааг 5-р сараас эхлүүлж, хог ургамал түүх болон идэвхтэй өсөлт хөгжилт ургалтын хугацаанд нэмэлтээр гумины шингэн бордоо хийж өгсөн. Хаврын нөхөн тарилтаар 1000 мод намарын тарилтаар 100 мод тарьж модны амьдралтын хувь 95%-тай ургаж байна.

Тус талбайд таригдсан модны усалгаа нь иж бүрэн дуслын усалгааны системээр тоноглогдсон ба модны эгнээ бүрийг дугаарлаж, намар бүх модонд 2 удаагийн давтамжтай 3 өдөр намарын цэнэг усалгаа хийж өвлийн бэлтгэл ажил хангав.



Зураг 5.1.1 Ажилчдын хотхоны гадна талбайн ногоон байгууламжийн усалгааны систем



Зураг 5.1.2 Ажилчдын хотхоны гадна талбайн ногоон байгууламж

5.2. Уурхайн орчмын ногоон байгууламжийн нөхөн тарилт

Эх орон байгаль дэлхийгээ хайрладаг хүн бүр байгалиа нөхөн сэргээх, хамгаалахад гар бие оролцох нөхцөлийг бүрдүүлэх, ойн сан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа олон талт ажлуудыг эрчимжүүлж, улмаар үндэсний хөдөлгөөн болгон өрнүүлэх зорилгоор Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар үндэсний мод тарих өдрийг жил бүр зохион байгуулдаг уламжлалтай болсон. Тэр бум мод үндэсний хөдөлгөөн Энэхүү мод тарих үндэсний өдрөөр нийтийн эзэмшлийн талбай болон ажилчдын хотхон, уурхайн зам дагуу, оффис орчимд уурхайн ажилчдын хамтаар нөхөн тарилтын ажлыг зохион байгуулав. Мөн уурхайн оффисын гадна явган зам дагуу 400м² талбайн зүлэгжүүлэлтийн ажил хийж гүйцэтгэсэн.

Баруун наран уурхайн Хаврын мод нөхөн тарилтын ажлыг 2025 оны 04 сарын 26-ны өдөр эхлүүлж, Оффис орчимд 300 ширхэг мод, сайтын кам дагуу 280 Намрын мод нөхөн тарилтыг 10 сарын 12,13-ны өдөр зохион байгуулж оффис орчимд нөхөн тарилтаар 420 суулгацыг нөхөн тарилтаар тарьсан. 2025 оны

байдлаар сайт болон уурхайн оффис орчим 1000 модыг нөхөн тарвсан байна. Уурхайн оффис орчим,сайтын зам дагуух ногоон байгууламжинд тарьсан модны амьдралтын 90% байна.



Зураг 5.2.1 Уурхайн зам дагуу хаврын нөхөн тарилт хийв.



Зураг 5.2.2 Оффис орчимд намрын нөхөн тарилт хийсэн.




Зураг. 5.2.2 Хавар намрын мод тарилт

5.3. Ховор, нэн ховор ургамал хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээ

Монгол орны улаан номонд орсон буйлс модыг үрээр 1000 ш бортогонд тарьж ургуулан, өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Буйлс нь хөрс голдоггүй ямарч хөрсөнд сайн ургадаг онцлогтой. Усалгаа бага шаардана. Буйлсны 3-4 настай суулгацыг цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбай, амьд хашаанд, бусад мод, сөөгтэй хослон тарихад тохиромжтой. Мөн элсний нүүлт зогсоох, хөрс хамгаалахад ашиглаж болно. Ургал эрхтэнээр үрждэггүй онцлогтой.



Зураг 5.3. Үрээр тарьж ургуулсан буйлс мод

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Уулын туруутан амьтдад зориулан хаврын улиралд биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Их уул	Их уул, Бага уул дахь уулын туруутан амьтад болон уурхайн бүсэд байгаа туруутан амьтдад зориулж нийт 30ш үржил шимт долоогчийг UARP, SGCM-ийн 6 ажилтан мөн Орон нутгийн идэвхтэн байгаль хамгаалагч н.Номинчулуун, н.Батсүхийн хамт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 3-р сарын 26-ны өдөр биотехникийн арга хэмжээг зохион байгуулав	2,000.0	Жилд 1 удаа
2	Зэрлэг амьтдад зориулсан уст цэгийг ажиллуулах	Их уул	Тайлант онд уст цэгийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, шаардлагатай засвар үйлчилгээний ажлыг хийж, худгийн хэвийн ажиллагааг ханган ажиллав. Уст цэгийн орчимд байрлуулсан хөдөлгөөн мэдрэгч камераар зэрлэг амьтны ажиглалтыг хийж байна	1,000.0	Жилд 1 удаа
3	Амьтдын амьдрах орчинг сайжруулах зорилгоор эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх	Баянцагааны нуруу орчим	Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Монгол орны хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон талбайг нөхөн сэргээх зорилтын хүрээнд манай компани Ханхонгор сумын Мандах багийн нутаг орших Гэр овоо нэртэй газар гар аргаар алт олборлосон 2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг ажлыг гүйцэтгэж, орон нутгийн ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.	13,600.0	2 га
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				16,600.0	

6.1. Уулын туруутан амьтдад зориулсан биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх

Их уул, Бага уул дахь уулын туруутан амьтдад болон уурхайн бүсэд байгаа туруутан амьтдад зориулж нийт 30ш үржил шимт долоогчийг UARP, SGCM-ийн 6 ажилтан мөн Орон нутгийн идэвхтэн байгаль хамгаалагч н.Номинчулуун, н.Батсүхийн хамт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 3-р сарын 26-ны өдөр биотехникийн арга хэмжээг зохион байгуулав. Их уулын уст цэгийн арын өврөөр болон баруун урд хэсгээр, Бага уулын зүүн урд хэсгээр тараан байршуулсан.



Зураг 6.1.1. Үржил шимт долоогч байршуулж буй байдал.



Зураг 6.1.2. Туруутан амьтдад зориулан тарааж тавьсан байдал

6.2. Зэрлэг амьтдад зориулсан уст цэгийг ажиллуулах

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагын суурь судалгааны үр дүн ба Өмнөговь аймгийн БОАЖГ-с өгсөн чиглэлд үндэслэн 2018 оноос хойш Ханхонгор сумын Хондот багийн нутаг болох Их ууланд уулын туруутан амьтдын популяцийг хамгаалах, амьдрах орчныг тэтгэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2020 онд байгуулсан уст цэгийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгаж, шаардлагатай засвар үйлчилгээний ажлыг хийж шинээр 2ш нарны зай хураагуурыг сольж, худгийн хэвийн ажиллагааг ханган ажиллав. Уст цэгийн орчимд байрлуулсан хөдөлгөөн мэдрэгч камераар зэрлэг амьтны ажиглалтыг хийж байна.



Зураг 6.2.1.. Зэрлэг амьтдад зориулсан уст цэгийн бүрэн бүтэн байдлыг тогтмол хангаж ажиллаж байна.



Зураг 6.2.2.. Их уулын уст цэг өдөрт 3 удаа ус гарах тохиргоотой ажиллаж байна.

6.3. Амьтдын амьдрах орчинг сайжруулах зорилгоор эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх

Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Монгол орны хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон талбайг нөхөн сэргээх зорилтын хүрээнд манай компани Ханхонгор сумын Мандах багийн нутаг орших Гэр овоо нэртэй газар гар аргаар алт олборлосон 2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг ажлыг гүйцэтгэж, орон нутгийн ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.



Зураг 6.3.2. Нөхөн сэргээлт хийхээс өмнө



Зураг 6.3.3 Нөхөн сэргээлт хийсний дараах зураг

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус компани нь 2012 оноос эхлэн төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн нийт айлыг нүүлгэн шилжүүлж нөхөн олговор олгосон бөгөөд одоогоор нүүлгэн шилжүүлэх өөр айл өрх байхгүй тул энэ онд нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой ажил уг төлөвлөгөөнд тусгагдаагүй болно.

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
7.1	Нөлөөллийн бүсийн айл өрхөд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх	Нөлөөллийн бүсийн айл өрх	Хондот багт 700 боодол өвс, Мандах баг, Жаргалант баг, Өгөөмөр багт тус бүр 400 боодол өвс нөлөөллийн бүсийн 20 өрхөд нийт 500 боодол өвс 125 уут тэжээлийн дэмжлэг тусламжийг үзүүлсэн байна.	Орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардлаас	2400 боодол өвс 125 уут тэжээл

7.1 Нөлөөллийн бүсийн айл өрхөд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх

Баруун наран уурхайн нөлөөллийн бүсийн малчид, орон нутгийн бусад малчин өрхүүддээ өвөл хаврыг өнтэй давахад нь туслах зорилгоор жил бүр өвс, тэжээлийн тусламжийг жил бүр үзүүлсээр ирсэн уламжлалтай. Баруун наран уурхайн зүгээс 2000 боодол өвсийг Дорнод аймаг болон Өег гурил ХХК-уудаас Хангамж худалдан авалтын багийн тусламжтайгаар худалдан авч тус тусын цэгүүд дээр татан төвлөрүүлсэн байна.

- Баруун наран уурхайн нөлөөллийн бүсийн 20 малчин өрхөд 25 боодол өвс 5уут тэжээл
- Ханхонгор сумын Хондот багт 800 боодол өвс
- Ханхонгор сумын малчин өрхүүдэд 500 боодол өвс



Зураг 7.1 Малчин өрхүүдэд өвс, тэжээлийн дэмжлэг үзүүлэв.

8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус компани нь 2012 оноос хойш холбогдох хууль ба компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд түүх соёлын биет ба биет бус өвийг хамгаалах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлсэн бөгөөд холбогдох хуулийн дагуу төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө археологи, палентлогийн хайгуул судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, авран хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Энэ онд түүх соёлын өвийг хамгаалах чиглэлээр үргэлжлэн хийгдэх ажил төлөвлөгдөөгүй бөгөөд цаашид түүх соёлын өвийг хамгаалах чиглэлээр тухай бүр шаардлагатай арга хэмжээг санаачлан зохион байгуулна.

9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Баруун наран уурхайн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл авах шаардлага бүхий химийн бодисыг ашиглахгүй бөгөөд химийн бодис ашиглах лаборатори болон бусад үйл ажиллагаа явагдахгүй болно. Баруун наран уурхайгаас олборлосон нүүрсний химийн шинжилгээ Ухаа худаг төслийн нүүрс химийн лабораторид хийгдэх юм. Тиймээс тус төлөвлөгөөнд химийн бодисын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй болно.

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Уурхайн ажиллагсдыг аюулгүй ажиллагаа, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах	Уурхайн хэмжээнд	Уурхайн ажиллагсдыг аюулгүй ажиллагаа, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалтыг давхардсан тоогоор 400 ажилтанд цаг тухай бүрт нь зохион байгуулан нийт операторуудын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэн ажиллаж байна.	500.0	1
2	Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийх	Баруун наран уурхай	Галын хорны үзлэг шалгалтыг сар бүрийн 01-ний өдөр дараах байршилд 220ш галын хорны үзлгийг тогтмол хийж байна. Үүнд: Засварын төв, галын сарай, уурхайд хөдөлгөөнд оролцож байгаа бүх техник	1,500.0	1
3	Галын эрсдэлээс сэргийлэх практик болон онолын сургалтыг нийт ажилтнуудад орох	Баруун наран уурхай	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу жил бүр гамшгаас урьдчилан сэргийлэх гамшгийн онолын сургалтад хамруулах, мөн түүнчлэн зарлан мэдээлэх дуут дохиогоор нийт төслийн талбайд ажиллаж байгаа 119 ажилтануудыг хамруулан дадлага сургуулалт хийсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Жилд 1 удаа
4	Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг нийт ажилчдад мэдээлэх	Нийт ажилтнуудад	7 хоног бүрийн цаг агаарын урьдчилсан мэдээг Дундын “Viber” чатанд байршуулж нийт ажилчдад тогтмол танилцуулж байна. Мөн ажилчдын ээлж солигдох, хот хоорондын зорчих хөдөлгөөний нөхцөл байдлыг талаар Өмнөговь-7053101, Дундговь-70593030 аймгуудын Онцгой байдлын	500.0	Сар бүр

			газартай холбогдож мэдээлэл авч ажилладаг		
5	ШТС-ын шугам хоолой, резервуар, арматур, холбоо -суудын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах	ШТС	ШТС нь өдөр шөнийн ээлжинд тогтмол 2 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Өдөр тутам галын аюулгүй байдал болон шугам хоолой, резервуаруудад холбогдох журам, шалгах үзүүлэлтүүдийн дагуу хяналт тавин ажиллан ээлж хүлээлцэн ажилладаг	500.0	Сар бүр
Нийт зардал				3,000.0	

9.1. Уурхайн ажиллагсдыг аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах

Баруун наран уурхайд ажиллахаар шинээр ирсэн бүх үндсэн болон гэрээт компанийн ажиллагсдад компанийн аюулгүй ажиллагаа, байгаль орчин, галын аюулгүй байдал, анхны тусламжийн 12 цагийн сургалтад хамруулсан. 2025 онд нийт 400 үндсэн болон гэрээт компанийн ажиллагсдыг сургалтад хамруулав.



Зураг 9.1.1. сургалтад хамрагдсан байдал

9.2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийх

Баруун наран уурхайн гэрээт олборлогч компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтнуудад гал унтраах автомашинд үзлэг шалгалт хийж, гал унтраах автомашины багаж хэрэгслийн ажиллуулах чиглэлээр заавар зөвлөмж өгсөн. Мөн уурхайн засварын байр, оффисийн галын аюулаас урьдчилсан сэргийлэх үзлэг шалгалт хийж, гал унтраагуурын даралт болон ажиллагааг шалгах зөвлөмжийг газар дээр нь өгч ажилласан.

Уурхайн галын булан, кэмп, засварын төв, Хово экскаватор зэрэг ашиглагдаж байгаа бүх техникүүдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг сар бүр хийж, бэлэн байдлыг тогтмол шалгаж ажиллаж байна. ГАУС-ын үзлэгээр илэрсэн зөрчлийг тухай бүрт арилган ажиллаж байна.



ГАЛ УНГААРУУР ДУГУУР КРАНТ ШАЛГАСАН ГЭМДЭГЭЛ				
а/д	Гал унгаруурын горал	Гал унгаруурын хэмжээ	Гал унгаруурын бичлэг	Шалгасан он, сар
1	ABC	1	Хүрэн	Хүрэн
2	ABC	1	Хүрэн	Хүрэн
3	ABC	1	Хүрэн	Хүрэн
4	ABC	1	Хүрэн	Хүрэн
5	ABC	1	Хүрэн	Хүрэн
6	ABC	1	Хүрэн	Хүрэн
7	ABC	1	Хүрэн	Хүрэн
8	ABC	1	Хүрэн	Хүрэн
9	ABC	1	Хүрэн	Хүрэн
10	ABC	1	Хүрэн	Хүрэн
11	ABC	1	Хүрэн	Хүрэн
12	ABC	1	Хүрэн	Хүрэн
13	ABC	1	Хүрэн	Хүрэн
14	ABC	1	Хүрэн	Хүрэн
15	ABC	1	Хүрэн	Хүрэн
16	ABC	1	Хүрэн	Хүрэн
17	ABC	1	Хүрэн	Хүрэн
18	ABC	1	Хүрэн	Хүрэн

9.3. Галын эрсдэлээс сэргийлэх практик болон онолын сургалт

Монгол Улсын Засгийн газрын 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүрийн гуравдугаар сарын дөрөв дэх пүрэв гаригийн 16.00 цагт гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дохиогоор дадлага сургууль зохион байгуулагддаг уламжлалтай. Гамшгийн аюулын дохио 2025 оны 03-р сарын 27-ны өдөр 16:00 цагт дуугарсны дараа Баруун наран уурхайн ажилтнууд цугларах цэгт цугларч дадлага сургуулилтад оролцов.



Зураг 9.3.1.. Дуут дохиогоор цугларах цэгт цугласан ажилтнуудын бүртгэл

Галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Баруун наран уурхайд галын аюулаас урьдчилан сэргийлэх дадлага сургуулилтыг 2025 оны 03-р сарын 27-нд уурхайд зохион байгуулж ажиллав. Галын дуудлагыг 13:43 минутад өгч 13:55 минутад галыг бүрэн унтрааж галд өртсөн ажилтанд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сургуулилт зохион байгуулав. Энэхүү дадлага сургуулилтан д тухайн үед ээлжинд ажиллаж байсан 95 хүнийг хамруулав.




Зураг 9.3.2. Галын дадлага сургуулилт

9.4. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээх

Компанийн хэмжээнд цаг агаарын 7 хоногийн урьдчилсан мэдээг мэдээллийн самбаруудаар болон и-мэйл хаягаар өдөр бүр мэдээллэдэг. Энэ онд хур тунадас их орсонтой холбоотойгоор цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээллийг компанийн и-мэйл хаяг, мэдээллийн самбарууд, олон нийтийн сүлжээгээр 10 гаруй удаагийн давтамжтай мэдээлсэн байна.


Цаг агаарын мэдээг 7 хоног бүрийн тогтсон өдрүүдэд болон уурхайн ээлж солигдох өдөр мессенжер чат, вайбер чатуудад байрлуулж байна.



Зураг 9.4.1.. Цаг агаарын мэдээг вайбар чатаар дамжуулан мэдээлдэг

9.5. ШТС-ын шугам хоолой, резервуар, арматур, холбоосуудын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах

Өмнөговь аймаг, Ханхонгор сумын нутаг дэвсгэрт байрлах Баруун наран шатахуун түгээх станц нь 2024 онд нэмэлтээр 50м³-ийн багтаамж бүхий 4 ширхэг савыг нэмж байрлуулан нийт 400м³ багтаамжтай, нэг хурдны түгээгүүр нэг энгийн түгээгүүр, нэг АСН-5 ачих гараар тоноглогдсон шатахуун түгээх станц юм. Баруун наран нүүрсний уурхайн түлшний өдрийн хэрэглээ нь дундажаар 50,000- 60,000 литр байгаа нь баруун зүүн уурхайн үндсэн 2 гүйцэтгэгчийн хэрэглээнд зориулан, станцын хүчин чадлыг 2 хуваан ашиглахад түлшний нөөц бүрдүүлэх боломж олгодоггүй байнгын нөөцгүй ажиллах шаардлага үүсч үйл ажиллагаа тасалдах эрсдэлийг нэмэгдүүлдэг. ШТС нь өдөр шөнийн ээлжинд тогтмол 2 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Өдөр тутам галын аюулгүй байдал болон шугам хоолой, резервуаруудад холбогдох журам, шалгах үзүүлэлтүүдийн дагуу хяналт тавин ажиллан ээлж хүлээлцэн ажилладаг.



35

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1.	Уурхай орчмын зам талбайд цэвэрлэгээ зохион байгуулах	Уурхай орчим	Тайлант хугацаанд уурхайн зам талбайд тархсан хог хаягдлын нийтийн цэвэрлэгээг бүх хэлтэс нэгжүүд хуваарийн дагуу 7 хоног бүрийн бямба гаригт хийж, нийт 41 удаа цэвэрлэгээг зохион байгуулсан. Цэвэрлэгээгээр нийт 12 м³ ахуйн хог хаягдал, 6м³ хуванцар хаягдлыг цэвэрлэн хог хаягдал түр хадгалах цэг рүү зайлуулсан.	500.0	Улирал тутам
2.	Хог хаягдлын ангиалан ялгалтыг 2 нэр төрлөөр нэмэгдүүлэн дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Хог хаягдал түр хадгалах цэгүүд	2025 онд Хог хаягдал ялгалтыг 2 төрлөөр нэмэгдүүлэх зорилгоор Е-хог хаягдал болон Органик хог хаягдал гэж ангиалан ялгалт нэмэгдүүлж ажиллаж байна.	1.000.0	Улирал тутам
3.	Хуванцарын хог хаягдлыг ангиалан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Засварын төв	Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулдаг Дүүрэн цэций ХХК-тай хог хаягдал нийлүүлэх гэрээг байгуулж Уурхайд үүссэн хуванцар савын хаягдлыг нүүлүүлж ажиллаж байна. 2025 оны байдлаар 173 м³ хуванцар сав нийлүүлсэн байна	Үйл ажиллага аны зардлаас	Улирал тутам
4.	Хаягдал тосыг шаардлага хангасан нөхцөлд цуглуулж, эрх бүхий байгууллагад нийлүүлэх	Тостой хог хаягдлын талбай	Засгийн газрын 2018 оны 116-р тогтоол “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам” ын дагуу “Хай Би Ойл” ХХК-тай аюултай хог хаягдал тээвэрлэх, нийлүүлэх гэрээг байгуулж, хаягдал тос болон аюултай хог хаягдлыг нийлүүлж байна	Үйл ажиллага аны зардлаас	Улирал тутам
5	Хог хаягдлын чиглэлээр сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид	“Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын тухай” журмыг засварын 2 ээлжийн нийт ажилчид, ахлах нарт 3 удаагийн давтамжтай сургалтыг орж нийт 79 хүн хамрагдсан байна	Үйл ажиллага аны зардлаас	1-р улиралд
6	Аюултай хог хаягдлыг нийлүүлэгч тал болон эрх бүхий байгууллагад буцаан хүргүүлэх, нийлүүлэх	Тосны сав, Аккумулятор	Уурхайд үүссэн Эмнэлгийн хог хаягдлыг гэрээний дагуу Цогтцэций сумын ЭМТ нийлүүлдэг. Мөн засварын төвөөс үүссэн аккумуляторыг дахин боловсруулах түүхий эд авах цэгт нийлүүлж ажиллаж байна.	16,000	Улирал тутам
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				19,000	

10.1. Нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах

Тайлант хугацаанд уурхайн зам талбайд тархсан хог хаягдлын нийтийн цэвэрлэгээг бүх хэлтэс нэгжүүд хуваарийн дагуу 7 хоног бүрийн бямба гаригт хийж, нийт 41 удаа цэвэрлэгээг зохион байгуулсан. Цэвэрлэгээгээр нийт 12 м³ ахуйн хог хаягдал, 6м³ хуванцар хаягдлыг цэвэрлэн хог хаягдал түр хадгалах цэг рүү зайлуулсан.



Зураг 10.1.1. Бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж буй байдал

10.2. Хог хаягдлын ангилан ялгалтыг 2 нэр төрлөөр нэмэгдүүлэн дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх

2025 онд төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлын ялгалтыг 2 төрөлд нэмэгдүүлэх зорилгоор е-хог хаягдал болон органик хог хаягдлыг ангилан ялгах ажлыг хэрэгжүүлж байна.

Уурхайн оффис болон ажилчдын амрах байранд нийт 2 е-хог хаягдлын сав байршуулан цуглуулж байна. Мөн төслийн нийт ажилтануудад өглөөний сэдэвчилсэн сургалтаар е-хог хаягдлын талаар мэдээлэл өгсөн.



Зураг 10.2.1. Е-Хог хаягдлын тухай нийт ажилчдад сургалт орж зориулалтын хогын сав байрлуулсан байдал.

2025 оны 4-10-р сарын хугацаанд органик хог хаягдалыг ялган цуглуулж 1 тн бордоо гарган авч ургамлын ялзмаг бордоог боловсруулан мод болон ургамлын ургалтыг нэмэгдүүлхэд ашиглаж байн



Зураг 10.2.2. Хоол үйлдвэрлэлээс гарсан органик хаягдлаар хийсэн бордоо.

10.3. Хуванцарын хог хаягдлыг ангилан ялгах



Ажилчдын хотхон, засварын байр, оффисийн өрөөнүүд, уулын зогсоолы талбай, түлш цэнэглэх хэсэгт хуванцар хог хаягдлыг ангилан ялгах зориулалтаар өнгөний код, тэмдэглэгээтэй савнуудыг байршуулсан. Хогийн саванд ангилагдсан хуванцар хаягдлыг хог хаягдлын гэрээт компани болох “Дүүрэн Цэций” ХХК-ийн дахивар авах цэгт хүргүүлж байна. Тайлант хугацаанд нийт 55.2 м³ хуванцрыг дахин боловслуулах үйлдвэрт хүргүүлсэн байна.



Зураг 10.3.1. Ажилчдын хотхоны өрөө, засварын байрны хуванцар сав цуглуулах сав



Зураг 10.3.2. Хуванцар савны бөглөө цуглуулах сав



Зураг 10.3.3. Хуванцар хаягдлыг хүлээлгэн өгөхийн өмнө ба дараа

10.4. Хаягдал тосыг шаардлага хангасан нөхцөлд цуглуулж, эрх бүхий байгууллагад шилжүүлэх

Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хаягдал тосыг зориулалтын нөөцлүүрт хадгалж эрх бүхий байгууллага болох “ХАЙ БИ ОЙЛ” ХХК-тай 2025 оны 03 сарын 01-нд АХХ-25/06 дугаартай гэрээг хийсэн. Гэрээ дагуу тайлант онд нийт 50.8 тонн хаягдал тос нийлүүлсэн.

Мөн түүнчлэн 11 тонн хаягдал тосыг түр эрх бүхий “Эко стандарт петролиум” ХХК-д нийлүүлсэн.



Зураг 10.4.1. Хаягдал тосыг эрх бүхий байгууллагад шилжүүлж байна

Зураг 10.4.2. Аюултай хог хаягдлын баримт

10.5. Хог хаягдлын чиглэлээр сургалт зохион байгуулах

Компанийн “Хог хаягдлын удирдлага зохицуулалтын журам”-ын агуулгаар уул, засвар, кемпийн ажилчдад сургалт, сэдэвчилсэн яриаг нийт 18 удаа зохион байгуулж, нийт 488 ажилтан хамрагдсан байна. “Хог хаягдлыг ангилан ялгаж хэвшье” уриалга бүхий сурталчилгааны зурагт хуудас бэлтгэн нийт ажилчдад тарааж, танилцуулсан.



Зураг 10.5.1. Хог хаягдлын талаар сургалтад хамрагдаж байгаа байдал

Зураг 10.5.1 Сургалт орсон байдал

10.6. Аюултай хог хаягдлыг нийлүүлэгч тал болон эрх бүхий байгууллагад буцаан хүргүүлэх, нийлүүлэх

Тайлант онд төслийн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдал болох тосоор бохирдсон сав 781ш, тосны шүүр 1000ш-ийг тусгай зөвшөөрөл бүхий “Түмэн эгшиг” ХХК-тай хийсэн гэрээний дагуу шилжүүлсэн.



Зураг 10.6.1 Эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр ачсан байгаа нь

Харин 39 ширхэг хаягдал аккумулятор, 70 ширхэг хаягдал бочкийг түр хадгалах талбайд хадгалж байна.



Зураг 10.6.2. Түр хадгалах талбайд хадгалж байгаа хаягдал аккумулятор, тосны бочканууд

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян. төг	Биелэлтийн шалгуур
1	Байгаль орчны хууль, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор дотоод хяналтыг хэрэгжүүлэх	Баруун наран төсөл	Гэрээт олборлогч компаниудын үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны осол, зөрчил, үл тохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчин, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн хэлтэс нь батлагдсан хуваарийн дагуу үзлэг шалгалтыг хийсэн. Ажлын байрны үзлэгээр 2025 оны 3 удаагийн үзлэгээр 10 үл тохирол илрүүлж, үл тохирол залруулалтын гүйцэтгэл 80% байна.	1,000.0	Нийт ажлын байрнууд дээр хуваарийн дагуу үзлэг хяналт хийж, үл тохирвол илэрвэл залруулах
2	Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдэд сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах	Баруун наран төсөл	Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Ерөнхий боловсролын сургуулийн “Хэрмийн бялзуухай” сурагчдын клубтэй хамтран Дэлхийн “Усны өдөр”, “Цэвэрлэгээний өдөр”, “Дэлхийн озоны давхаргыг хамгаалах өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулсан. Сурагчдын хими, физик, биологийн туршилт хийж, шинжлэх ухаанч сэтгэлгээг хөгжүүлж дэмжлэг үзүүлэх зорилгоор “Гэртээ туршъя” багц хэрэгслэлийг хүлээлгэн өгсөн.	1,000.0	Бүх нийтээр түгээмэл тэмдэглэдэг 3 доошгүй өдрүүд
3	Ус ашигласны төлбөрийг ноогдуулалтын дагуу төлж барагдуулах ажилд хяналт тавих	Баруун наран төсөл	Ус ашигласны төлбөрийг хуулийн хугацаанд тухай бүр төлж байгаа болно.	Үйл ажиллагаа ны зардал	Сар бүр төлбөрийг төлж барагдуулах
4	Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх		Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох шаардлагын дагуу Баруун наран төслийн байгаль орчны хууль эрх зүйн нийцлийн 2 жил тутмын аудитыг 2023 онд гүйцэтгэж байсан аудитын эрх бүхий мэргэжлийн байгууллага болох БОАД ХХК ажиллаж байна. 2025	18,000	Байгаль орчны хууль эрх зүйн төлөвлөгөөт аудит хийлгэх

			оны 10-р сарын 14-ний өдөр аудитын нээлтийн цахим уулзалт болон баримт бичгийн хяналтыг хийн аудитын ажлын урьдчилан үзлэгийн дүгнэлт гаргасан.		
5	Байгаль орчны ажилтнуудыг чадавхижуулах сургалт болон туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулах, хурал, семинар, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох		Байгаль орчны ажилтнуудыг чадавхижуулах ажлын хүрээнд 2025 оны 02-р сарын 20-25-ны өдрүүдэд гэрээт олборлогч компанийн байгаль орчны ажилтан Д.Нямбаяр ISO 9001, 14001, 45001 дотоод аудиторын сургалтад амжилттай хамрагдаж чадамжийн сертификаттай болсон. Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвөөс зохион байгуулсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх судалгаа шинжилгээний ажлыг олон улсын жишигт хүргэж, байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагааг төлөвшүүлэх” сургалтанд 2025 оны 6-р сарын 16-17-ны өдрүүдэд байгаль орчны ажилтан Н.Төгөлдөр хамрагдав.	1,000.0	ISO Стандарт болон ногоон байгууламжийн чиглэлээр, Салбарын чиглэлийн аливаа үйл ажиллагаанд санаачлагатай оролцох
6	Идэвхитэн байгаль хамгаалагчийн ажилд дэмжлэг үзүүлэх		Ханхонгор сумын Хондот багийн малчин Сайн дурын байгаль хамгаалагч Номинчулуунд 2025 оны 6-р сард өвөл зуны ажлын хувцас хэрэглэл, гэрэл, халуун баригч саваар дэмжлэг үзүүлэн ажиллав. Ханхонгор сумын Хондот багийн малчин сайн дурын идэвхтэн байгаль хамгаалагч Батсүхийн хүсэлтийн дагуу 2025 оны 10 дугаар сарын 11-ны өдөр малын 2 хорооны бууц түрэх ажлыг хийж гүйцэтгэсэн.	1,000.0	Их болон бага уулын 2
БОМТ-ний зардал, мян.төг				22,000.0	

Тус ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Ханхонгор сумын ЕБС-ийн “Хэрмийн бялзуухай” клубийн багш сурагчтай хамтран ажиллаж, Хүрээлэн буй орчноо цэвэрлэж, хайрлаж хамгаалахын ач тус, Дэлхийн озоны тухай танин мэдэхгүйн ярилцлага хийж, хамтран мэдээлэл солилцож, “Ёлын ам” орчмын хогийг цэвэрлэж, хөгжөөнт АХА тэмцээн зохион байгуулан, дурсгалын зүйл гардуулан өгч, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгүүрүүлээ.



Зураг 11.2.1 “Ёлын ам”-ийн түр амрах отогт АХА тэмцээнээ амжилттай зохион байгуулж, ярилцлага хийв.



Зураг 11.2.2 Үдийн цай ууж, ойролцоох хэсэг газрын хогийг цэвэрлэв..



Зураг 11.2.3 “Хэрмийн бялзуухай” клубийн хамт олонд дурсгалын зүйл гардуулав..



Зураг 11.2.3 Хүүхдүүдийн хамтаар Музей үзэж, “Гэртээ туршья” багц хэрэгслийг хүлээлгээж өгсөн..

11.3. Ус ашигласны төлбөрийг ноогдуулалтын дагуу төлж барагдуулах ажилд хяналт тавих

Төслийн үйл ажиллагаанд ашиглах ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны дүгнэлт зөвшөөрлийг хуулийн дагуу авч, ус ашигласны төлбөрийг усны ашиглах дүгнэлтийн дагуу сар тутамд төлж байна.

Зураг 11.3.1. Усны төлбөр төлсөн баримт

11.4. Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох шаардлагын дагуу Баруун наран төслийн байгаль орчны хууль эрх зүйн нийцлийн 2 жил тутмын аудитыг 2023 онд гүйцэтгэж байсан аудитын эрх бүхий мэргэжлийн байгууллага болох БОАД ХХК ажиллаж байна. 2025 оны 10-р сарын 14-ний өдөр аудитын нээлтийн цахим уулзалт болон баримт бичгийн хяналтыг хийн аудитын ажлын урьдчилан үзлэгийн дүгнэлт гаргасан.

**"ХАНГАД ЭКСПЛОРЭЙШН" ХХК-НИН ӨМӨГӨӨН, АЙМГИЙН ХАМООРОН
СУМАЙН БАЙРАЛТАЙ "БАРУУН НАРАН" НУУРСНИЙ УУРХАЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТЫН ҮЭСЛЭГИЙН ҮЗЛЭГТ
БОЛОН УРЬДЧИЛАН ҮЗЛЭГИЙН ДҮГНЭЛТ**

Урьдчил:

"БОАД" ХХК болон "Хангад эксплорэйшн" ХХК-ийн хамтарсан ИДЭ-25-132 дугаартай "Байгаль орчны аудитын үйлчилгээ" гэрээ-ний дүрээр 2025 оны 10 сарын 14-ний өдөр "Хангад эксплорэйшн" ХХК-ийн Өмөнгөл, аймгийн Хангоор сумын нутаг дэвсгэрийн "Баруун наран" нуурын уурхайн үйл ажиллагаанд "БОАД" ХХК-ийн 6 хүний бүтэцтэй аудитын баг Монгол Улсын "Байгаль орчны хамгаалах тухай хууль"-ийн 10-р зүйлийн зорилго бичигдсэн байна. Байгаль орчны аудитын багийн гишүүд:

№	Овог, нэр	Чиг үүрэг	Аудитын чиглэл	Аудиторын гэрчилгээ
1.	О.Алтансүх	Ассист аудитор	Усан орчны менежмент	2013/001
2.	Д.Дамбажаргал	Аудитор	Хоронго орчны ба газрын менежмент	2013/025
3.	Б.Батсайхан	Аудитор	Агаарын чөлөө, амьсгалуурын системийн менежмент	2013/035
4.	Н.Солонгон	Аудитор	Хөдөө ажлаах менежмент	2015/010
5.	Б.Байрамаа	Аудитор	Хүний бэлэн ажилттай болон менежмент	2015/120
6.	Т.Батзориг	Аудитор	Бичиг баримт бичиг ба бичиг баримт менежмент	2015/119

Хэлтэлийн үзлэгт болон урьдчилсан үзлэгт үйл ажиллагаа:


Аудитын багийн гишүүн төлөөлөгчид хамтаар "Баруун наран" нуурын уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь очиж ажиглах, урьдчилсан дүгнэлт гаргах зорилготой.

Хэлтэлийн үзлэгт болон урьдчилсан үзлэгт үйл ажиллагаа:

Аудитын багийн гишүүн төлөөлөгчид хамтаар "Баруун наран" нуурын уурхайн үйл ажиллагаатай газар дээр нь очиж ажиглах, урьдчилсан дүгнэлт гаргах зорилготой.

Тусгай зөвшөөрлийн гажуудлыг ажиглах:

Утас	Өргөрөг
105° 10' 0"	43° 37' 00"
105° 16' 0"	43° 35' 00"
105° 10' 0"	43° 38' 00"
105° 16' 0"	43° 34' 00"



Зураг 1. Төстийн талбай

1/3

Говийн бүс нутаг дэвсгэрийн амьдрах чадвар өндөрэйг үнэм, хайлаа, жид, суай жидүүдэн 2 настай сууцныг жид бүр өндөрэй лонгоор илжж тарж арчиж ургууцдг.



Зураг 5. Ургамалжуулалт

Газрын төсөн бүтээгдэхүүний стандартын шаардлага хангаан зориулалтын агуулж, саванд хадгалдаг. СХЯ-аас татасуул түгээгддг бүрт элмүүд, зарцуулалтын хэмжээг хяргасгийн байгальжуулалтын гэрчилгээтэй.



Зураг 6. Шахааны агуулж ба түгээгддг

Урьдчилсан үзлэгт үйл ажиллагаа:

"Хангад эксплорэйшн" ХХК-ийн Өмөнгөл, аймгийн Хангоор сумын нутаг дэвсгэрийн "Баруун наран" нуурын уурхайн үйл ажиллагаанд 2025 оны 10 сарын 14-ний өдөр байгаль орчны менежментийн аудитын багийн гишүүн төлөөлөгчид хамтаар "Баруун наран" нуурын уурхайн үйл ажиллагаанд "БОАД" ХХК-ийн 6 хүний бүтэцтэй аудитын баг Монгол Улсын "Байгаль орчны хамгаалах тухай хууль"-ийн 10-р зүйлийн зорилго бичигдсэн байна. Байгаль орчны аудитын багийн гишүүд:

Байгаль орчны менежментийн аудитын гэрээний дүрээр усан орны менежмент, биосистийн системийн менежмент, агаар орны менежмент, хөдөө ажлаах менежмент, хүний бэлэн ажилттай болон менежмент, бичиг баримт бичиг ба бичиг баримт менежмент зэрэгт үйл ажиллагааг хянаж байсан байна. Байгаль орчны менежментийн аудитын гэрээний дүрээр усан орны менежмент, биосистийн системийн менежмент, агаар орны менежмент, хөдөө ажлаах менежмент, хүний бэлэн ажилттай болон менежмент, бичиг баримт бичиг ба бичиг баримт менежмент зэрэгт үйл ажиллагааг хянаж байсан байна. Байгаль орчны менежментийн аудитын гэрээний дүрээр усан орны менежмент, биосистийн системийн менежмент, агаар орны менежмент, хөдөө ажлаах менежмент, хүний бэлэн ажилттай болон менежмент, бичиг баримт бичиг ба бичиг баримт менежмент зэрэгт үйл ажиллагааг хянаж байсан байна.



О.АЛТАНСҮХ

3/3

Зураг 11.4.1. Аудитын ажлын урьдчилан үзлэгийн дүгнэлт

11.5.1. Байгаль орчны ажилтнуудыг чадавхижуулах

Байгаль орчны ажилтнуудыг чадавхижуулах ажлын хүрээнд 2025 оны 02-р сарын 20-25-ны өдрүүдэд гэрээт олборлогч компанийн байгаль орчны ажилтан Д.Нямбаяр ISO 9001, 14001, 45001 дотоод аудиторын сургалтад амжилттай хамрагдаж чадамжийн сертификаттай болсон.



Зураг 11.5.1. БО-ны ажилтан Д.Нямбаяр ISO 9001, 14001, 45001, стандартын аудиторын сургалтанд хамрагдсан.

11.5.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх судалгаа, шинжилгээний ажлыг олон улсын жишигт хүргэж, байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагааг төлөвшүүлэх сургалт

Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвөөс зохион байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх судалгаа, шинжилгээний ажлыг олон улсын жишигт хүргэж, байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагааг төлөвшүүлэх сургалт"

ажиллагааг төлөвшүүлэх” сургалтанд 2025 оны 6-р сарын 16-17-ны өдрүүдэд байгаль орчны ажилтан Н.Төгөлдөр хамрагдав.

Энэхүү сургалтын зорилго нь уул уурхайн биологийн болон техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийх, нөхөн сэргээлтийн хууль эрхзүйн орчныг сайжруулах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, хог хаягдлын эрхзүйн орчин, аюултай хог хаягдлыг тээвэрлэх, хадгалах, цуглуулах болон уул уурхайн үйл ажиллагааны улмаас доройтсон экосистемийг нөхөн сэргээх талаар ойлголт мэдлэг олгох, ур чадварыг дээшлүүлэх юм.

11.6 Идэвхитэн байгаль хамгаалагчийн ажилд дэмжлэг үзүүлэх

Ханхонгор сумын Хондот багийн малчин Сайн дурын байгаль хамгаалагч Номинчулуунд 2025 оны 6-р сард өвөл зуны ажлын хувцас хэрэглэл, гэрэл, халуун баригч саваар дэмжлэг үзүүлэн ажиллав.



Зураг 11.6.1 Сайн дурын байгаль хамгаалагчид өвөл зуны ажлын хувцас гардуулж өгч байна.

Ханхонгор сумын Хондот багийн малчин сайн дурын идэвхтэн байгаль хамгаалагч Батсүхийн хүсэлтийн дагуу 2025 оны 10 дугаар сарын 11-ны өдөр малын 2 хорооны бууц түрэх ажлыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 11.6.2. Сайн дурын идэвхтэн байгаль хамгаалагч Батсүхийн малын хорооны бууц түрэв.

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

12.1. Газрын доорхи усны хяналт шинжилгээ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Гар худгуудын усны түвшин болон эрдэсжилт, ЦДЧ, рН хэмжих.	Уурхай орчимд байрлах малчдын 3 гар худаг	2025.10.31-ний байдлаар Уурхайн нөлөөллийн бүсийн 3 гар худагт нийт 30 удаа хэмжилт хийсэн.	800.0	Сар тутамд хэмжилт хийгдсэн байх
2	Малчдын гар худгуудын усны чанарын хяналт.	Уурхай орчимд байрлах малчдын 3 гар худаг	Сар бүр уурхайн нөлөөллийн бүсэд байгаа малчдын 3 худгийн усны чанарын хяналтыг тогтмол хийж байна.	500.0	Усны ерөнхий химийн шинжилгээ хийлгэсэн байх
3	Ундны усны эх үүсвэрүүдээс дээж авч шинжилгээ хийлгэх	Кемп болон уурхайн 4 цэгт	Баруун наран уурхайн шопын худгийн ус болон ажилчдын амрах байрны хэрэглээний усны цэгүүдээс дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.	300,0	Жилд 1 удаа шинжилгээ хийлгэсэн байх
Нийт				1,600.0	

12.1.1. Гар худгуудын усны түвшний хэмжилтийн тайлан

Баруун наран уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд уурхай орчмын малчдын “Богвойн шанд, Эрдэнэтолгойн худаг, Их бууц” зэрэг гар худгуудын усны түвшин болон эрдэсжилт, ЦДЧ, рН хэмжилтийг 1-10 сарын хооронд 10 удаа нийт 30 удаагийн хээрийн хэмжилтийг хийж, бүртгэл хөтөлсөн.



Зураг 12.1.1.1 Малчдын гар худгуудын хэмжилт хийж буй байдал

Хүснэгт 12.1.1 Малчдын худгийн усны физик үзүүлэлт хэмжилтийн үр дүн

Худгийн нэр	Богвойн шанд				Эрдэнэтолгой				Их бууц			
	Орчин	Эрсджилт	Темпартур	Дээжлэлт хийсэн эсэх	Орчин	Эрсджилт	Темпартур	Дээжлэлт хийсэн эсэх	Орчин	Эрсджилт	Темпартур	Дээжлэлт хийсэн эсэх
2025.01.25	4.9	587	1	Үгүй	6.7	714	2	Үгүй	5.5	693	1.4	Үгүй
2025.02.26	5	560	1	Үгүй	10	547	7	Үгүй	7.4	565	5.9	Үгүй
2025.03.19	6	510	6	Үгүй	9	647	9	Үгүй	7.8	602	8.1	Үгүй
2025.04.20	7.3	1200	5.9	Үгүй	9.3	560	6.3	Үгүй	8.4	650	7.5	Үгүй
2025.05.27	8.5	1330	10	Үгүй	10.5	1150	8.7	Үгүй	7.8	720	10	Үгүй
2025.06.12	6.4	1204	19.4	Үгүй	10.2	712	12	Үгүй	8	807	16	Үгүй
2025.07.26	8.2	1320	24.1	Үгүй	8.5	680	23	Үгүй	8.9	850	19.6	Үгүй
2025.08.12	9	1187	17.3	үгүй	9.1	1135	17	Үгүй	9.7	1275	18.2	Үгүй
2025.09.07	8.4	1080	16	үгүй	9.8	1058	14.2	Үгүй	8.2	1193	15	Үгүй
2025.10.18	8.9	1126	14	Тийм	9.2	1121	13	Тийм	8.9	1201	14	Тийм

График 12.1.1.3



Малчдын худгуудын усны түвшний хэмжилтийн үр дүнд Богвойн шандын ус болон Их бууц худаг нь 2025 оны 10 удаагийн хэмжилтээр усны түвшин тогтмол нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Эрдэнэтолгойн худгийн усны түвшин нь 1-р сараас 3-р сар хүртэл харьцангуй тогтвортой байсан бол 4-9 р сард усны түвшин 0.7 м болон 0.41 м-ээр тус тус нэмэгдсэн үр дүн ажиглагдаж байна.

12.1.2. Малчдын гар худгуудын усны чанарын хяналт

Малчдын гар худгуудын уснаас дээж авч ерөнхий химийн шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний дүнг MNS 900:2018 “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага” стандарттай харьцуулан дүнг боловсрууллаа.

Хүснэгт 12.1.2.1. Худгийн усны химийн үзүүлэлтийн шинжилгээний үр дүн

№	Шинжилгээний үзүүлэлтүүд	Стандарт	Богвойн шанд	Их бууц	Эрдэнэ толгой
1	Өнгө, градус	20	3.51	21.5	35.08
2	ЦДЧ ц/см	1.0	1.33	0.86	0.70
3	Үлдэгдэл чөлөөт хлор (Cl ₂), мг/л	0.2-0.3	≥2	≥2	≥2
4	Усны орчин, pH	6.5-8.5	7.95	7.74	8.32
5	Ерөнхий хатуулаг, мг-экв/л	7	2.34	3.96	1.59
6	Аммоны ион (NH ₄), мг/л	1.5	≤0.05	0.11	≤0.05
7	Нитритийн ион (NO ₂), мг/л	1	0.017	0.010	0.008
8	Фторид (F), мг/л	1.25	≥2	≥2	≥2
9	Нийт төмөр (Fe), мг/л	0.3	≤0.05	0.07	0.17

MNS 900:2018 “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага” стандартаас хэтэрсэн үзүүлэлтүүдийг дээрх хүснэгтэнд улаанаар тэмдэглэв.

Харьцуулалтын үр дүнд өнгө, градус, Эрдэнэтолгой, Их бууц худгуудад хэтэрсэн бол цахилгаан дамжуулах чадвар Богвойн шанд дээр хэтэрсэн үзүүлэлттэй байна. Бусад үзүүлэлтүүд нь стандартын шаардлага хангаж байна

12.1.3. Ундны усны эх үүсвэрүүдээс дээж авч шинжилгээ хийлгэх

Баруун наран уурхайн унд ахуйн ашигладаг 3 худгийн уснаас авч итгэмжлэгдсэн АЛС лабораторид микроэлементийн шинжилгээг хийлгэсэн.

Хүснэгт 12.1.3.1. Ундны усны шинжилгээний үр дүн

Элементүүд	Al	As	Ba	Cd	Cr	Cu	Fe	Mn	Mo	Pb	Sb	Sr	V	Zn	Ni
MNS 6148:2010	0.5	0.01	2	0.003	0.07	1	0.3	0.1	0.04	0.05	0.006	-	0.06	5	0.1
MNS 900:2018	0.5	0.01	0.7	0.003	0.05	1	0.3	0.1	0.07	0.01	0.02	2	-	5	0.02
Кемпийн худаг	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	0.01	0.08	0.02	0.01	<0.02	<0.04	0.7	0.01	0.01	<0.01
Засварын худаг	0.03	<0.01	0.02	<0.01	<0.01	0.01	0.06	0.02	0.01	<0.02	<0.04	2.98	<0.01	0.18	<0.01
Шүүрлийн ус баруун	0.07	<0.01	0.03	<0.01	<0.01	0.01	0.06	0.01	0.04	<0.02	<0.04	1.98	<0.01	0.01	<0.01
Баруун худаг	0.05	<0.01	0.03	<0.01	<0.01	0.06	0.06	0.39	<0.01	<0.02	<0.04	3.79	<0.01	0.08	<0.01
Шүүрлийн ус зүүн	0.01	<0.01	0.02	<0.01	<0.01	<0.01	<0.01	0.04	0.01	<0.02	<0.04	6.07	<0.01	0.01	0.06

Ундны усны микроэлементийн шинжилгээний үр дүнг MNS 900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарттай харьцуулан үзэхэд стандартаас хэтэрсэн үзүүлэлт ажиглагдахгүй байна.

12.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян. төг	Биелэлт ийн шалгуур
1	Уурхайгаас үүсэх нарийн ширхэгт тоосыг хянах зорилгоор РМ 2.5 хэмжээтэй тоосонцорын концентрацийг тодорхойлох	Уурхай орчимд байрлах 3	Уурхайгаас гарах нарийн ширхэгт тоосыг хянах зорилгоор РМ 2.5 хэмжээтэй тоосонцорын концентрацийг тодорхойлж Баруун наран уурхайд байнгын 3 цэгт тоосонцорын хэмжилтийг 1 цагийн хугацаатайгаар нийт 30 хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.	900.0	Сар тутамд 3 цэгт хэмжилт хийгдсэн байх
3	Гадаад орчны агаарын чанарын \ NO ₂ , SO ₂ , хэмжилт хийх .	Уурхай Ажилчдын хотхон ШТС	“Ногоон титэм” ХХК-ний мэргэжилтэн “Баруун наран” уурхайн Агаарын чанарын хэмжилтийг 2025.04.17 өдөр хийсэн.	800.0	Жилд 1 удаа 6 цэгт
Нийт				1,700.0	

12.2.1. Гадаад орчны тоосны концентрацийн хэмжилт

Уурхайгаас гарах нарийн ширхэгт тоосыг хянах зорилгоор РМ 2.5 хэмжээтэй тоосонцорын концентрацийг тодорхойлж Баруун наран уурхайд байнгын 3 цэгт тоосонцорын хэмжилтийг 24 цагийн хугацаатайгаар нийт 30 хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн үр дүнг MNS 4585:2025 “Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага” Монгол улсын стандарттай харьцуулан дүгнэлт гаргасан.



Зураг 12.1.1 Баруун Наран уурхай орчмын тоосны хэмжилт хийж буй байдал




График 1. Баруун Наран уурхайн тоосны концентрацийн хэмжилтийн үр дүн

Дээрх графикаас харахад PM 2.5 нарийн ширхэглэгт тоосонцрын хэмжилтийн үр дүнд 8-р сард 404 болон 10-р сард 402, 404 пост дээр стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй, Бусад саруудын хэмжилт стандартаас хэтсэрсэн тохиолдол байхгүй байна.

12.2.3. Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээ

Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээний хүрээнд бохирдуулагч хий болох азотын давхар исэл, хүхрийн давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл, хүхэрт устөрөгч, зэрэг хийнүүдийг итгэмжлэгдсэн “Ногоон титэм” лабораториор шинжүүлсэн болно. Агаараас дээж авах хэмжилт хийх ажлыг Ногоон титэм лабораторийн химич ирж гүйцэтгэсэн болно. Агаарын чанарын найрлагын дээжийг уурхай шатахуун түгээх станц, ажилчдын хотхон, ажилчдын хотхоны цэвэрлэх байгууламж гэсэн нийт 4 цэгээс авсан.



Зураг 12.2.2.1 Хэмжилт хийж буй байдал

Хүснэгт 12.2.2.1. Агаарын шинжилгээний дүн, мкг/м³

Цэгийн нэр үзүүлэлт	Агаарын чанарын MNS4585:2025 стандарт	Уурхай	Шатахуун түгээх станц	Ажилчдын хотхон	Цэвэрлэх байгууламж
Хүхэрлэг хий SO ₂ , мкг/м ³	450 мкг/м ³	104.99	<0.5 ³	<0.5	266.16
Азотын давхар исэл мкг/м ³	200 мкг/м ³	57.58	71.91	57.67	47.23
Нүүрстөрөгчийн дутуу исэл мкг/м ³	1800 мг/м ³	<1	<1	<1	<1
Хүхэрт устөрөгч	-		0.00	-	25.51

Дээрх дүнгээс харахад азотын давхар исэл, хүхрийн давхар ислийн хэмжилтийн дүнг агаарын чанарын MNS4585:2025 стандарттай харьцуулахад хүхэрлэг хий SO₂ уурхай болон ШТС-ын орчимд стандартаас хэтэрсэн үзүүлэлттэй байсан бол бусад хэсэгт хэтэрсэн үзүүлэлт ажиглагдахгүй байна.

12.3 Хөрсний судалгаа

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Баруун наран уурхай болон дэд бүтцийн барилга байгууламж орчмын хөрснөөс микро элементийн дээж авч шинжлүүлэх	Баруун наран уурхай орчим цэг Засварын төв, ШТС, Хогийн цэг хяналтын 10 цэг	Хэмжилтийн 10 цэгээс дээж авч АЛС лабораторид шинжлүүлсэн	400.0	Жилд 1 удаа шинжилгээ хийлгэсэн
2	Хөрсний агрохимийн шинжилгээ	Шимт хөрсний овоолгууд	Шимт хөрсний 8 овоолгоос дээж авч Инженер Геодезийн хөрсний лабораторид шинжилгээ хийлгэсэн	300.0	Жилд 1 удаа шинжилгээ хийлгэсэн
Нийт				700.0	

12.3.1 Хөрсний микро элементийн шинжилгээ

Баруун наран уурхайн хөрсний бохирдлыг хянах зорилгоор 10 цэгээс дээж авч АЛС хөрсний итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээ хийлгэсэн.

Хүснэгт 12.3.1.1. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

№	Байршил	Pb	Cd	Hg	As	Cr	Sr	V	Cu	Ni	Co	Zn	B
MNS 5850:2019		100	3	2	20	150	800	150	100	150	50	300	25
1	Харьцуулах цэг	10	<0.5	<1	12	26	50	47	26	23	10	54	10
2	Кэмийн хатуу хог түр хадгалах цэг	10	<0.5	<1	10	26	65	46	28	23	9	54	10
3	/ Уурхайн ШТС	10	<0.5	<1	8	23	44	45	25	20	9	51	10
4	Нүүрс ачиж буулгах талбайн урд	15	<0.5	1	16	11	327	47	79	43	22	132	10
5	Уурхайн засварын төв	10	<0.5	<1	7	21	194	41	38	22	10	59	30
6	Уурхайн засварын төв SGC/	7	<0.5	<1	11	26	127	94	32	31	16	68	10
7	Уурхайн цэвэрлэх байгууламж	12	<0.5	<1	7	11	168	24	50	24	12	77	10
8	Кэмийн цэвэрлэх байгууламж	9	<0.5	<1	9	25	71	48	27	22	9	53	10
9	Кэмийн авто зогсоол	10	<0.5	<1	10	35	107	58	33	28	11	56	10
10	Уурхайн аюултай хог хаягдлын цэг	14	<0.5	<1	8	21	195	39	43	26	13	74	10

Баруун наран уурхай болон дэд бүтцийн барилга байгууламж орчмын 5 цэгийн хөрснөөс микро элементийн шинжилгээ өгсөн. Шинжилгээний дүнгээс харахад MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт ажиглагдахгүй байна.

12.3.2. Хөрсний агрохимийн шинжилгээ

Баруун наран уурхайн шимт хөрсний овоолгын 8 цэгээс дээж авч 2025 оны 04 дүгээр сарын 26-28-ны өдөр хөрсний агрохимийн шинжилгээг “Инженер геофизи ХХК”-д хийлгэсэн.

12.3.2.1. Хүснэгт Хөрсний агрохимийн шинжилгээний дүн

Дээжний нэр	Шимт хөрс 2016		Шимт хөрс 2018		Шимт хөрс 2019		Шимт хөрс 2020		Шимт хөрс 2021		Шимт хөрс 2022		Шимт хөрс 2023		Шимт хөрс 2024	
ОН	2025	2024	2025	2024	2025	2024	2025	2024	2025	2024	2025	2024	2025	2024	2025	2024
pH	8.36	8.68	8.68	8.74	8.95	8.45	8.91	9.51	8.8	0	8.7	8.65	8.78	8.53	8.48	8.64
ЦДЧ dsm	0.626	0.85	0.18	0.474	0.146	0.239	0.157	0.179	0.132	0	0.175	0.316	0.158	0.231	0.165	0.261
Давс %	0.31	0.41	0.09	0.23	0.07	0.11	0.07	0.08	0.06	0	0.08	0.15	0.07	0.11	0.08	0.12
Ялзмаг %	0.97	0.92	1.23	1.18	0.94	1.07	0.88	0.8	1.19	0	1.43	0.71	1.82	0.8	0.37	0.99
CaCO ₂ %	0.99	1.65	0.82	1.48	0.66	0.82	0.66	0.82	0.99	0	1.65	1.32	0.82	2.8	1.15	1.96
Шингээгдсэн сууриуд, мг-экв/100	Ca	16.9	11.9	14.6	9.4	9.2	6.1	8.8	3.5	12.1	0	17.6	10.5	12.6	12.7	12.2
	Mg	8.4	6	5.8	5.4	8.4	4.4	4.8	2.3	8.4	0	14.3	4.9	8	4	11
Шимт тэжээлийн элементүүд	P ₂ O ₅	2.4	2.6	2.1	2.1	2.5	2.8	1.9	1.9	1.7	0	2.4	0.8	2.2	0.8	1.4
	K ₂ O	25	23	28	42	21	31	20	25	20	0	23	22	29	23	19

Шинжилгээний үр дүнг 2024 оны шинжилгээний үр дүнтэй харьцуулан үзэхэд pH, ЦДЧ үзүүлэлтүүд харьцангуй зөрүү багатай байсан. Хөрсний үржил шим тэжээлийн гол үзүүлэлт нь хөрсний ялзмаг байдаг бөгөөд шимт хөрсний ялзмаг нь өмнөх оныхоос 0.3-аас 0.7%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь жилийн дундаж хур тунадасны хэмжээ өмнөх оныхоос их байсантай холбоотой байж болно. ЦДЧ болон хөрсний давслагийн хэмжээ хэмжээ мөн адил өмнөх оныхоос бага хэмжээгээр буюу 0.1-ээс 0.5% нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад үзүүлэлтийн хувьд харьцангуй өөрчлөлт багатай байгаа нь ажиглагдаж байна.

12.3.2.2. Хүснэгт Баруун наран уурхайн шимт хөрсний овоолгын механик бүрэлдэхүүн

Дээжний нэр		Шимт хөрсний овоолго 2016	Шимт хөрсний овоолго 2018	Шимт хөрсний овоолго 2019	Шимт хөрсний овоолго 2020	Шимт хөрсний овоолго 2021	Шимт хөрсний овоолго 2022	Шимт хөрсний овоолго 2023	Шимт хөрсний овоолго 2024
Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм	1-0.25	24.8	22.2	28.6	22.9	30.4	27.9	37.6	58.4
	0.25-0.05	44.1	54.3	52.2	60.3	53.9	43.1	40.4	26.5
	0.05-0.01	13.7	6.4	5.9	4.8	2.2	8.4	5.7	5
	0.01-0.005	4.6	3.9	3.9	2.8	2.4	3.9	2.3	0.6
	0.005-0.001	6.9	8.6	7.2	6.3	7.8	10.9	9.8	6.5
	<0.001	5.9	4.6	2.2	2.8	3.3	5.9	4	3.1
	<0.01	17.4	17.1	13.3	12	13.5	20.6	16.2	10.2

Хөрсний механик бүрэлдэхүүн нь 2 мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракц нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Элсний ширхгийн хэмжээ 2-0.05мм, тоосных 0.05-0.002мм, шаварных <0.002мм тус тус байдаг (“Guidelines for soil description”. 2006). Судалгааны үр дүнгээс харахад хөрсөн дэх элсэн фракцын утгын хэлбэлзэл буюу 1-0.05 мм-д 53.1% - 72.5% байсан. Тоосны фракцын утгын хэлбэлзэл буюу 0.05-0.01 мм-ийн хооронд 1.1% - 11% байна. Шаврын фракцын утгын хэлбэлзэл буюу 0.01->0.001 мм-ийн хооронд 20.9% - 39.9% байсан. Дээрх графикийн үзүүлэлтээс харахад хөрсний

механик бүрэлдэхүүний ихэнх хувийг элсэн фракц 1-0.05 мм эзэлж байгааг харуулж байгаа ба харин тоос болон шаварлаг бүтэц нь харьцангуй бага байгааг харуулж байна.


12.4. Ургамал, Амьтны аймгийн судалгаа

№	Хяналт шинжилгээний төрөл	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал, төг	Тоо хэмжээ
1	Ургамлын аймгийн судалгаа хийх	Их уул	2025 оны 09-р сард Авралын эрэлд ХХК-аар Баруун наран уурхай орчимд ургамлын 4 цэгт мониторингийн судалгаа хийлгүүлж тайланг хүлээж авсан.	7,000.0	Жилд 1 удаа 4 цэг
2	Амьтны судалгаа хийлгэх		2025 оны 09-р сард Авралын эрэлд ХХК-аар Баруун наран уурхайн биологийн олон янз байдлын мониторингийн судалгаа хийлгүүлж тайланг хүлээж авсан.	-	Жилд 1 удаа 1 цэг
				11,000	

12.4.1 Ургамлын бүрхэвчийн судалгаа

2025 оны 09-р сард Авралын эрэлд ХХК-аар Баруун наран уурхайн биологийн олон янз байдлын мониторингийн судалгаа хийлгүүлж тайланг хүлээж авсан.

Төслийн талбай орчимд ургамалжилтын мониторингийн 4 цэгт бичиглэл хийж боловсруулахад Хялгана - баглуурт, Баглуур – Таанат, Хялгана – Баглуур – Таанат, Таанат гэсэн цөлөрхөг хээрийн ургамлын 4 бүлгэмдэл илрэв..



Зураг 12.4.1.1 Ургамалжилтын мониторинг судалгааны цэгийн байршил

Ургамлын мониторинг судалгааны талбай болон тухайн газар орчмын зүйлийн бүрэлдэхүүнд ургамлын аймгийн задлан шинжилгээ хийхэд судалгааны талбайд нийт 6 овгийн 25 төрөлд хамаарах 29 зүйлийн гуурст дээд ургамал бүртгэгдэв. Өмнөх судалгаанд бүртгэгдсэн зүйлийн бүрэлдэхүүнээс даруй 11 зүйл ургамал нэмж бүртгэгдэж байгаа энэ жил хур тунадас элбэгтэй, ургамлын ургалт сайнтай холбоотой байж болох юм.

Баруун Наран уурхай орчимд ургамал бүлгэмдлийн доройтлыг илэрхийлэгч зүйлүүд болох Харлаг өмхий өвс (*Peganum nigellastrum*), Амманы сэдэргэнэ (*Convolvulus ammannii*), Саваан булган сүүл (*Chloris virgata*), Шүлхий шарилж (*Neopallasia pectinata*) цөөнгүй бүртгэгдсэн нь газрын өнгөн хөрс элэгдэлд орсон, хүн, машин техник, дэд бүтэц нэмэгдэж, ихэссэн зэрэг хүний үйл ажиллагаатай шууд болон дам холбоотой. Энэ жил хур бороо сайтай, зуншлага сайн байсны улмаас чийгсэг нэг наст зүйлүүд түлхүү ургадаг онцлогтой хэдий ч өмнөх онуудад хийгдсэн судалгааны дүнтэй харьцуулахад тус уурхай орчмын ургамлын бүлгэмдэл доройтож эхэлж байна гэж дүгнэсэн.



Зураг 12.4.1.2 Ургамлын судалгаа хийж буй

Баруун Наран уурхай орчимд хийсэн ургамалжилтын судалгаагаар Хялгана - баглуурт, Баглуур – Таанат, Хялгана – Баглуур – Таанат, Таанат гэсэн цөлөрхөг хээрийн ургамлын 4 бүлгэмдэл илрэв.

Ургамлын мониторинг судалгааны талбай болон тухайн газар орчмын зүйлийн бүрэлдэхүүнд ургамлын аймгийн задлан шинжилгээ хийхэд судалгааны талбайд нийт 6 овгийн 25 төрөлд хамаарах 29 зүйлийн гуурст дээд ургамал бүртгэгдэв. Өмнөх судалгаанд бүртгэгдсэн зүйлийн бүрэлдэхүүнээс даруй 11 зүйл ургамал нэмж бүртгэгдэж байгаа энэ жил хур тунадас элбэгтэй, ургамлын ургалт сайнтай холбоотой байж болох юм.


Баруун Наран уурхай орчимд ургамал бүлгэмдлийн доройтлыг илэрхийлэгч зүйлүүд болох Харлаг өмхий өвс (*Peganum nigellastrum*), Амманы сэдэргэнэ (*Convolvulus ammannii*), Саваан булган сүүл (*Chloris virgata*), Шүлхий шарилж (*Neopallasia pectinata*) цөөнгүй бүртгэгдсэн нь газрын өнгөн хөрс элэгдэлд орсон, хүн, машин техник, дэд бүтэц нэмэгдэж, ихэссэн зэрэг хүний үйл ажиллагаатай шууд болон дам холбоотой. Энэ жил хур бороо сайтай, зуншлага сайн байсны улмаас чийгсэг нэг наст зүйлүүд түлхүү ургадаг онцлогтой хэдий ч өмнөх онуудад хийгдсэн судалгааны дүнтэй харьцуулахад тус уурхай орчмын ургамлын бүлгэмдэл доройтож эхэлж байна гэж дүгнэхээр байна.

12.4.2 Амьтны судалгаа

Их уул талбайн хэмжээ нь нийт 28760 га байна. Үүний 87% хэвийн амьдрах орчинд хамаарч байгаа бол үлдсэн 13% өөрчлөгдсөн ангилалд хамаарна. Мөн чухал амьдрах орчин байхгүй болно. Их уул орчмын 3570 га талбайг мөн орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна.

Бага уул: талбай нь 4403 га бөгөөд үүний 70 орчим хувь нь өөрчлөгдсөн ангилалд хамаарч байгаа бол үлдсэн 30 хувь нь хэвийн ангилалд хамаарна. Бага уулыг ямар нэгэн хамгаалалтад аваагүй байна.

Баруун наран уурхайгаас биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд бий болгосон нарны өргүүрээр ажилладаг автомат худгийн зургаас харвал жилийн 4-10 сарын дунд хүртэл аргаль хонь, янгир ямаа, үнэг, хярс, цагаан зээр, ооч ёл, нөмрөг тас, начин шонхор, зэрэг амьтад ирсээр байгаа нь тухайн жилд унах хур тунадастай холбоотойг харуулна.



Зураг 12.4.2.1. Их уул, бага уул орчмын амьдрах орчин

Уулын туруутан амьтдын боломжит амьдрах орчны болон шилжилт хөдөлгөөний загварт голлох нөлөөлж буй хүчин зүйлсийг авч үзвэл: Эко системийн хэв шинж, гадаргын өндөршил, тухайн жилийн агаарын дундаж температур, ургамалжилтын хэв шинж, хүйтэн улирлын дундаж температур, газрын гадаргын налуу, зүг зовхис, жилийн дундаж хур тунадас, улирлын дундаж температур зэрэг хүчин зүйлсийн нөлөө орж байна.

Энэ бүс нутагт тархсан хөхтөн амьтны судалгааг судлаачдын өөрсдийн сүүлийн 10 орчим жилийн хугацаанд цуглуулсан мэдээллийг ашиглан зүйлийн жагсаалтыг боловсруулсан болно. Үүнд: Таван толгойн, Баруун наран орчим, түүний эргэн тойрны бэсрэг уулс, нам толгод, хөндийгөөр 6 баг, 10 овогт хамаарах 23 зүйлийн хөхтөн амьтныг бүртгэлээ. Үүнд мах идэштний багаас саарал чоно, шар үнэг, хярс, шилүүс, эрээн хүрнэ, өмхий хүрнэ, хадны суусар, туруутнаас аргаль хонь, янгир ямаа, цагаан зээр, хар сүүлт зээр, туурайтнаас хулан адуу, зарааны багаас дэлдэн зараа, туулай хэлбэртнээс бор туулай, мэрэгчдээс улбар шанаат зурам, монгол чичүүл, шар чичүүл, элсний зусаг, орог зусаг, говийн алагдаага, сибирь алаг даага, савагдаахай, сүүлэрхэг шишүүхэй зэрэг байна.

**13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ**

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа	Тайлан мэдээлэл хүлээн авах тал	Гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Мод тарьсан айлуудад зөвлөгөө мэдээлэл өгөх	Ханхонгор сумын Хондот баг	Ханхонгор сумын Хондот багын малчин Т.Сугибаатар 200 ширхэг модыг 2023 онд ахуйн зориулалттай тарьсан бөгөөд тус модны талбайн усалгааг машинаар зөөвөрлөж гараар усалдаг ажиллагаа ихтэй 100 м усалгааны 63-тай хоолой, 200 м нарийн 16-тай хоолой, дуслын систем, усалгааны систем хүссэн хүсэлтийг шийдвэрлэж уурхайгаас бүрэн олгосон. Мөн тус багийн малчин Ц.Түмэнбаярт 100м дуслын усалгааны систем хүссэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.	500.0	Багийн нийтийн хурал зохион байгуулагдах үед
2	Хамтын оролцоотой мониторинг	Хондот багийн мод тарьсан иргэд	Баруун наран уурхайн удирдах ажилтнууд, байгаль орчны хэсэг болон Орон нутгийн харилцааны нэгжүүд, Ханохонгор сумын засаг дарга Наранжаргал, Байгаль хамгаалагч Ц.Батбэх, Татварын байцаагч Б. Нямсүрэн, хэлтэсийн төлөөлөгч Н. Тогмид худаг ашиглагч 15 малчин нийт 27 хүн оролцсон.	500.0	Жилд 1 удаа
3	Компанийн үйл ажиллагааны, байгаль орчны гүйцэтгэлийн талаарх мэдээлэл	Ханхонгор сумын ЗДТГ-т	Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Хондот багийн иргэдийн нийтийн оны сүүлийн хуралд оролцож компанийн танилцуулга мэдээлэл өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.	300.0	Жилд 1 удаа

4	Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн тооллого хийх	Ханхон гор сумын дөрвөн багийн иргэд	Монгол улсын Агаарын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-479 тушаалаар батлагдсан журмын дагуу Агаарын бохирдлын суурин болон хөдөлгөөнт эх үүсвэрийн бүртгэлийг гарган Өмнөговь аймгийн Ханхонгор сумын засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.	400.0	Жилд 1 удаа
5	Байгаль хамгаалах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр мэдээлэл өгөх	Өмнөговь аймаг БОАЖГ	Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн санаачилгаар Австралийн засгийн газрын Australia Awards-Mongolia хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Австралийн Квинсландын их сургуультай хамтран хэрэгжүүлсэн Carbon Conscious Mining in Mongolia сургалтын уул уурхайн төлөөлөл 25 оролцогчид компанийн нөхөн сэргээлтийн бодит туршлага үр дүнгийн талаар танилцуулга хийсэн.	Цахим ар	Сар бүр
Нийт			1,400.0		

13.1. Мод тарьсан айлуудад зөвлөгөө мэдээлэл өгөх

Ханхонгор сумын Хондот багын малчин Т.Сугибаатар 200 ширхэг модыг 2023 онд ахуйн зориулалттай тарьсан бөгөөд тус модны талбайн усалгааг машинаар зөөвөрлөж гараар усалдаг ажиллагаа ихтэй 100 м усалгааны 63-тай хоолой, 200 м нарийн 16-тай хоолой, дуслын систем, усалгааны систем хүссэн хүсэлтийг шийдвэрлэж уурхайгаас бүрэн олгосон. Мөн тус багийн малчин Ц.Түмэнбаярт 100м дуслын усалгааны систем хүссэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.



13.1.1. Ц.Түмэнбаярт усалгааны систем хүлээлгэн өгсөн.

13.2. Хамтын оролцоотой мониторинг

Баруун наран уурхайн удирдах ажилтнууд, байгаль орчны хэсэг болон Орон нутгийн харилцааны нэгжүүд, Ханохонгор сумын засаг дарга Наранжаргал, Байгаль хамгаалагч Ц.Батбэх, Татварын байцаагч Б. Нямсүрэн, хэлтэсийн төлөөлөгч Н. Тогмид худаг ашиглагч 15 малчин нийт 27 хүн оролцсон. Баруун наран уурхайн нөлөөллийн бүсэд худгийн хэмжилтийг “Богвойн шанд” малчны гар худгийн усны түвшин 35см хэмжилт хийсэн. Өмнөх хэмжилттэй харьцуулахад усны түвшин буураагүй. Усны хүчил шүлтийн орчин /усан орчин/-г хэмжиж үзэхэд PH-8,5-тай гарсан нь ундны усанд хэрэглэх боломжтой байсан. Эрсдэлжилт буюу TDS-г хэмжиж үзэхэд 1520-тай гарсан нь ундны усанд хэрэглэхэд эрдэсжилт өндөртэй, давсархаг устай. Температур 7.3 градустай байсан. Эрдэнэтолгой малчдын гар худгийн усны түвшинг хэмжихэд усны түвшин 1 метр байсан. Усны түвшин буураагүй. Усны хүчил шүлтийн орчин /усан орчин/-г хэмжиж үзэхэд PH-6,0-тай гарсан нь ундны усанд хэрэглэх боломжтой байсан. Эрсдэлжилт буюу TDS-г хэмжиж үзэхэд 856-тай гарсан нь ундны усанд хэрэглэхэд өндөртэй, давсархаг устай. Температур 3,5 градустай байсан.

Харин тоосны хэмжилтийг Баруун наран уурхайн оффисын гадна талбайд хийж хэмжилтийн багажийн танилцуулга болон хэмжилтийн үр дүнг танилцуулав. Хэмжилтийн үр дүнгээс үзэхэд тоосжилтын хэмжээ нь 0.007 мг/м3 буюу байсан нь Монгол улсын агаарын чанарын MNS 4585:2025 стандартаас бага үзүүлэлттэй байсан.



13.2.1. Хамтын оролцооны мониторинг.

13.3. Компанийн үйл ажиллагааны, байгаль орчны гүйцэтгэлийн талаарх мэдээлэл танилцуулах

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Хондот багийн иргэдийн нийтийн оны сүүлийн хуралд оролцож компанийн танилцуулга мэдээлэл өгөх төлөвлөгөөтэй ажиллаж байна.


13.4 Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн тооллого

Монгол улсын Агаарын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А-479 тушаалаар батлагдсан журмын дагуу Агаарын бохирдлын суурин болон хөдөлгөөнт эх үүсвэрийн бүртгэлийг гарган Өмнөговь аймгийн Ханхонгор сумын засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.

Зураг 13.4.1. Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн бүртгэл

3.5. Байгаль хамгаалах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр мэдээлэл өгөх

Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн санаачилгаар Австралийн засгийн газрын Australia Awards-Mongolia хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Австралийн Квинсландын их сургуультай хамтран хэрэгжүүлсэн Carbon Conscious Mining in Mongolia сургалтын уул уурхайн төлөөлөл 25 оролцогчид компанийн нөхөн сэргээлтийн бодит туршлага үр дүнгийн талаар танилцуулга хийсэн.



Зураг 3.5.1 Танилцуулга хийж буй нь

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төлөвлөсөн зардал 99.2 сая төгрөг бөгөөд түүний барьцаа болох 49.6 сая төгрөгийг Төрийн сангийн тусгай дансанд Хангад Эксплорэйшн компаниас байгаль орчин хамгаалах төлөвлөгөөний барьцаа болгон шинээр байршуулсан болно.

№	Хийгдэх ажлын чиглэл	Хийгдсэн ажлын тодорхойлолт	Зарцуулалт, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	14,900.00
2	Нөхөн сэргээлт	Мод сөөг үржүүлэх, ногоон байгууламжийн усалгаа арчилгаа, мод тарих	11,000.00
3	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	16,600.0
4	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор	Нөлөөллийн бүсийн малчид болон сумдын иргэдэд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах	Ажил төлөвлөгдөөгүй	-
6	Осол эрсдэлийн менежмент	ХАБЭА БО-ны сургалт зохион байгуулах, Гамшгаас хамгаалах ба Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллах	3,000.0
7	Хог хаягдлын менежмент	Хог хаягдлын ангилан ялгалтын нэр төрлийг нэмэгдүүлэх, хог хаягдал түр хадгалах цэгийг сайжруулах,	19,000.0
8	Удирдлага зохион байгуулалт	Байгаль орчны дотоод хяналтыг зохион байгуулах, Газрын хянан баталгаа, Сургалт мэдээлэл	22,000.0
9	Орчны хяналт шинжилгээ	Усны хяналт шинжилгээ	1,600.0
		Агаарын чанарын хяналт шинжилгээ	1,700.0
		Хөрсний хяналт шинжилгээ	700.0
		Ургамлан бүрхэвчийн судалгаа	7,000.0
10	Олон нийтэд тайлагнах	Мониторингийн ажилд олон нийтийг оролцуулах, төрийн байгууллагад мэдээ тайлан хүргүүлэх	1,700.0
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг			99,200.0